МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ПАРЛАМЕНТЫН ТОГТОЛЦООТОЙ УЛС ОРНУУДЫН ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Судалгааны төрөл:	**Харьцуулсан судалгаа**
Судалгааны код:	СТ-25/242
Огноо:	2025.10.13
Захиалагч:	Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн
Хянасан:	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр
Судалгаа удирдсан:	Судалгааны хэлтсийн зөвлөх Г.Билгээ
Судлаач:	Судалгааны хэлтсийн референт Б.Сарантуяа

Улаанбаатар хот
2025

АГУУЛГЫН ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ ii
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ iii
УДИРТГАЛ 1
НЭГ. ПАРЛАМЕНТЫН ТОГТОЛЦООТОЙ УЛС ОРНУУДЫН ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ 2
1.1. Халдашгүй байдлын эрх зүйн үндэс 2
1.2. Хариуцлагаас чөлөөлөгдөх (non-accountability) зохицуулалтын харьцуулалт 5
1.3. Халдашгүй байдлын (inviolability) зохицуулалтын харьцуулалт 10
ХОЁР. ГИШҮҮНИЙ ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ 30
2.1. Хариуцлагаас чөлөөлөгдөх (non-accountability)-д холбогдох олон улсын эрх зүйн зохицуулалт 30
2.2. Халдашгүй байдал (inviolability)-д холбогдох олон улсын эрх зүйн зохицуулалт 32
ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН 38
НОМ ЗҮЙ 41

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АСЕАН	Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНЭстУ	Бүгд Найрамдах Эстони Улс
ЕХ	Европын Холбоо
ЕХЭШ	Европын Хүний Эрхийн Шүүх
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
APA	Asian Parliamentary Assembly (Азийн Парламентын Ассамблей)
ASEAN	Association of Southeast Asian Nations (Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг)
CJEU	Court of Justice of the European Union (Европын Холбооны Шүүх)
ECB	European Central Bank (Европын Төв Банк)
ECHR	European Convention on Human Rights (Европын Хүний эрхийн конвенц)
EctHR	European Court of Human Rights (Европын Хүний эрхийн шүүх)
EGGVG	Einführungsgesetz zum Gerichtsverfassungsgesetz (Introductory Act to the Courts Constitution Act - Германы Шүүхийн байгуулалтын тухай хуулийн хэрэглэх журам)
GVG	Gerichtsverfassungsgesetz (Courts Constitution Act - Германы Шүүхийн байгуулалтын тухай хууль)
ICC	International Criminal Court (Олон улсын эрүүгийн шүүх)
OWiG	Gesetz über Ordnungswidrigkeiten (Act on Regulatory Offences Германы Захиргааны зөрчлийн тухай хууль)
PACE	Parliamentary Assembly of the Council of Europe (Европын Зөвлөлийн Парламентын Ассамблей)
PPI	Protocol on the Privileges and Immunities of the European Union (Европын Холбооны Тусгай эрх, дархан эрхийн тухай протокол)
RiStBV	Richtlinien für das Strafverfahren und das Bußgeldverfahren (Guidelines for Criminal and Regulatory Offence Proceedings - Германы эрүүгийн болон захиргааны зөрчлийн ажиллагааны удирдамж)
RoP	Rules of Procedure (Дотоод журам / Үйл ажиллагааны журам)
StGB	Strafgesetzbuch (Criminal Code of Germany - Германы Эрүүгийн хууль)
StPO	Strafprozessordnung (Code of Criminal Procedure of Germany - Германы Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль)
ZPO	Zivilprozessordnung (Code of Civil Procedure of Germany - Германы Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль)

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан орнуудын парламентын гишүүний халдашгүй байдлыг зохицуулж буй хуулиуд 3
Хүснэгт 2. БНСУ-ын Үндэсний Ассамблейн тухай хууль дахь гишүүний үг хэлэх эрхтэй холбоотой зохицуулалтууд 5
Хүснэгт 4. БНСУ-ын Үндэсний Ассамблейн тухай хууль дахь гишүүний халдашгүй байдалд холбогдох зохицуулалт 10
Хүснэгт 5. БНСУ-ын Үндэсний Ассамблейн гишүүдийн баривчлах, саатуулах зөвшөөрөлд холбогдох статистик (1948-2024 он) 13
Хүснэгт 6. БНСУ-ын Үндэсний Ассамблейн гишүүдийн баривчлах зөвшөөрлийн талаарх санал, шийдвэрийн статистик тойм 14
Хүснэгт 7. БНСУ-ын Үндэсний Ассамблейн гишүүдийн баривчландсан болон суллах хүсэлтийн тоо, түүний шийдвэрлэгдсэн байдал (1948-2024) 15
Хүснэгт 8. БНСУ-ын ардчилсан Үндсэн хуульт Үндэсний Ассамблей байгуулагдсанаас хойших гишүүний халдашгүй байдалд холбогдох статистик 16
Хүснэгт 9. ХБНГУ-ын Бундестагийн гишүүний халдашгүй байдлыг түдгэлзүүлэхтэй холбоотой зарчмууд (Бундестагийн дотоод дэгийн тухай хууль, 6 дугаар хавсралт) 21
Хүснэгт 10. Япон Улсын Үндэсний парламентын тухай хуульд гишүүний халдашгүй байдлыг зохицуулсан нь 28
Хүснэгт 11. Парламентын халдашгүй байдлын хүрээнд хариуцлагаас чөлөөлөгдөхөд хамаарах олон улсын эрх зүйн зохицуулалт 30
Хүснэгт 12. Парламентын халдашгүй байдалд холбогдох олон улсын эрх зүйн зохицуулалт 32
Хүснэгт 13. Судалгаанд хамрагдсан улсуудын парламентын халдашгүй байдлын харьцуулалт 39

УДИРТГАЛ

“Парламентын тогтолцоотой улс орнуудын парламентын гишүүдийн халдашгүй байдлын талаарх эрх зүйн зохицуулалт” судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны хамрах хүрээ:

Харьцуулсан судалгааг хоёр үндсэн чиглэлээр хийнэ. Үүнд, нэгдүгээрт, парламентын тогтолцоотой улс орнуудын парламентын гишүүдийн халдашгүй байдлыг (inviolability) хууль эрх зүйн хүрээнд хэрхэн зохицуулдаг, түүний жишээ, үр нөлөө, харьцуулалтыг Япон, БНСУ, БНЭстУ, ХБНГУ-ыг харьцуулан судална.

Хоёрдугаарт, гишүүний халдашгүй байдлын талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээ, гэрээ, конвенцын зохицуулалтыг судална. Энэ хүрээнд, НҮБ, Европын Холбоо, Европын Парламентын Дотоод Судалгааны Ерөнхий Газар (Directorate-General for Internal Policies)-ын Иргэдийн эрх ба Үндсэн хуулийн асуудлын бодлогын хэлтэс, Европын Төв Банк, Олон улсын парламентын холбоо, Азийн Парламентын Ассамблей, Европын Зөвлөлийн Парламентын Ассамблей, Венецийн комисс зэрэг байгууллагууд болон Европын Холбооны Шүүх, Европын Хүний эрхийн шүүх, Олон улсын эрүүгийн шүүхийн баримт бичгийг хамруулна.

Судалгааны ажлын бүтэц:

Судалгааны тайлан үндсэн хоёр хэсэгтэй байна. Үүнд:

1. парламентын тогтолцоотой улс орнуудын парламентын гишүүдийн халдашгүй байдлыг (inviolability) хууль эрх зүйн хүрээнд хэрхэн зохицуулдаг, түүний жишээ, үр нөлөө, харьцуулалтыг Япон, БНСУ, БНЭстУ, ХБНГУ-ыг харьцуулна;
2. гишүүний халдашгүй байдлын талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээ, гэрээ, конвенцын зохицуулалтыг судална.

Судалгааны арга зүй:

- харьцуулсан шинжилгээний арга;
- хууль зүйн баримт бичгийн судалгааны арга.

Судалгааны арга зүй, аргачлал:

Монгол: *парламентын онцгой эрх, хариуцлагаас чөлөөлөх, халдашгүй байдал, парламент дахь үг хэлэх эрх чөлөө, хууль зүйн хариуцлагаас чөлөөлөх, халдашгүй байдал (тодорхой нөхцөлд баривчлагдахаас чөлөөлөх).*

Англи: *parliamentary privilege, non-accountability, inviolability, freedom of speech in parliament, non-liability (irresponsibility), inviolability (freedom from arrest in certain cases).*

НЭГ. ПАРЛАМЕНТЫН ТОГТОЛЦООТОЙ УЛС ОРНУУДЫН ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ

1.1. Халдашгүй байдлын эрх зүйн үндэс

Парламентын халдашгүй байдал нь парламентын гишүүдэд олгогддог хууль зүйн хамгаалалт бөгөөд тэднийг бүрэн эрхийн хугацаанд баривчлах, саатуулах, яллагдагчаар татахаас хамгаалдаг (Venice Commission, 2014). Харин гэмт хэрэг үйлдэж байхдаа баригдсан (flagrante delicto) тохиолдолд энэхүү хамгаалалт үйлчлэхгүй (OSCE, 2004). Энэ хамгаалалт нь парламент дахь үг хэлэх, санал өгөх эрх чөлөө (non-liability)-нөөс ялгаатай бөгөөд гишүүний парламентын бус үйл ажиллагаанд хамаардаг (Venice Commission, 2014). Зорилго нь парламентын бие даасан, чөлөөтэй үйл ажиллагааг хангах явдал бөгөөд парламентын халдашгүй байдал нь ихэнх улс оронд хоёр үндсэн хэлбэрээр илэрдэг. Нэгдүгээрт, парламент дахь үг хэлэх, санал өгөхтэй холбоотой бүрэн хамгаалалт (non-accountability) нь байнгын, цуцлагдашгүй шинжтэй байдаг. Хоёрдугаарт, гишүүнийг бүрэн эрхийн хугацаанд баривчлах, яллагдагчаар татахаас хамгаалах түр зуурын хамгаалалт (inviolability) байдаг. Тус бүрийн тодорхойлолтыг дэлгэрүүлэн үзвэл:

- ***Хариуцлагаас чөлөөлөх*** (non-accountability) - парламентын гишүүний парламентын танхимд хэлсэн үг, эсхүл парламентад төлөөлөх эрхээ хэрэгжүүлэх хүрээнд хэлсэн үг, өгсөн саналтай холбоотой аливаа хууль зүйн арга хэмжээнээс хамгаалагдах эрх байна. Хариуцлагаас чөлөөлөх (non-accountability) гэх нэршил нийтлэг боловч улс орнууд ялгаатайгаар нэрлэж хэрэглэдэг тохиолдлууд байна. Тухайлбал, англи хэлтэй орнуудад “non-accountability”, “parliamentary privilege”, эсхүл “freedom of speech” гэж нэрлэдэг. Франц, Бельгид “irresponsabilité”, Италид “insindacabilità”, Германд “Indemnität”, **эсхүл** “Verantwortungsfreiheit”, Австрид “berufliche Immunität”, Испанид “inviolabilidad”, Швейцарт “absolute Immunität”, **эсхүл** “immunité absolue” гэж нэрлэдэг (Venice Commission, 2014).
- ***Халдашгүй байдал*** (inviolability) - баривчлах, саатуулах, яллах болон бусад арга хэмжээнээс хязгаарлагдмал хүрээнд хамгаалах хамгаалалт буюу энэ нь хариуцлагаас чөлөөлөх хүрээнд хамрагдахгүй, өөрөөр хэлбэл, парламентын мандатын хэрэгжилтээс гадуур хийсэн үйлдэл, мэдэгдэлд хамаарна. Парламентын гишүүдийн халдашгүй байдалд хамаарах энэ ойлголт нь хариуцлагаас чөлөөлөгдөх эрхтэй харьцуулахад түгээмэл биш. Халдашгүй байдал нь ихэвчлэн илүү нарийн хүрээнд хэрэглэгдэж, олон төрлийн онцгой нөхцөлд хэрэгжихгүй байх боломжтой, мөн парламент өөрөө цуцалж болдог (Venice Commission, 2014). Халдашгүй байдал (inviolability) гэх томьёоллыг өөрөөр нэрлэх хэрэглэх тохиолдлууд цөөнгүй байна. Тухайлбал, “immunity in the strict sense”, эсхүл “freedom from arrest” гэж хэрэглэдэг. Зарим улсад тухайлбал, Франц, Бельгид “inviolabilité”, Германд “Immunität”, эсхүл “Unverletzlichkeit”, Австрид “ausserberufliche Immunität”, Испанид “inmunidad”, Швейцарт “relative Immunität”, эсхүл “immunité relative” гэж нэрлэдэг (Venice Commission, 2014).

  Европын Зөвлөлийн дэргэдэх Венецийн комиссын “Парламентын дархан эрхийн хамрах хүрээ ба түдгэлзүүлэх тухай тайлан (Report on the scope and lifting of parliamentary immunities)”-д парламентын гишүүний дархан эрхийг буруугаар ашиглах, дур зоргоор шийдвэр гаргах эрсдэлийг бууруулах; дархан эрхийг түдгэлзүүлэх үйл явцын ил тод, шударга, нэр томьёог нэг мөр ойлгон хэрэглэх журам тогтоох; улс орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалтыг харьцуулан шинжилж, нийтлэг Европын шалгуур гаргах хүрээнд парламентын гишүүний дархан эрхийн

хоёр үндсэн хэлбэрийг ялгаж суурь ангиллыг тодорхойлсон байдаг. Тус тайланд парламентын гишүүний дархан эрхийг *“immunity”* гэх томьёоллоор хэрэглэж дархан эрхийн хоёр үндсэн хэлбэрийг 1) хариуцлагаас чөлөөлөх (non-accountability өөрөөр, non-liability) буюу хариуцлагаас чөлөөлөх эрх (үг хэлэх, санал өгөх эрх чөлөө); 2) халдашгүй байдал (inviolability) буюу баривчлах, саатуулах, мөрдөн шалгах, яллах зэргээс хамгаалах эрхийг тодорхойлсон байна. Үүнээс дархан эрх (immunity) гэх ойлголт нь 1) хариуцлагаас чөлөөлөх (non-accountability) болон 2) халдашгүй байдал (inviolability)-ийг аль алийг нь өөртөө хамруулан авч үздэг өргөн хүрээтэй ойлголт байна.

Энэхүү судалгаагаар дээрх хоёр нэр томьёонд холбогдох БНСУ, БНЭстУ, ХБНГУ, Япон Улсын зохицуулалтыг харьцуулсан судалсан.

Хуулиар ардчилал тогтоох Европын комисс (Венецийн комисс) эдгээр нэр томьёо болон зохицуулалтыг судалж, “non-accountability” гэх нэршлийг “ерөнхийдөө үндэслэлтэй, өөрчлөлт хийх шаардлага багатай” гэж дүгнэсэн (Venice Commission, 2014). Харин “inviolability” гэх нэр томьёог орчин үеийн сайн ажилладаг ардчиллын зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг биш бөгөөд “ардчиллыг сулруулах, эрх зүйт ёсыг зөрчих, шударга шүүхийн үйл явцыг саатуулах байдлаар буруу ашиглагдаж болзошгүй” гэж үзсэн байдаг (Venice Commission, 2014).

Судалгаанд хамруулсан орнуудын эрх зүйн зохицуулалтаас харахад, парламентын гишүүдийн халдашгүй байдал нь үндсэндээ төрийн эрх мэдлийн хуваарилалт, парламентын бие даасан байдлыг баталгаажуулах зорилготой бөгөөд Үндсэн хууль болон органик хуулиар ихэвчлэн зохицуулсан байна. Иймээс судалгааны ажлын энэ бүлгийн дэд хэсгүүдэд сонгон авсан улс орнууд парламентын гишүүний халдашгүй байдлыг Үндсэн хууль болон органик хуулиудаар хэрхэн зохицуулсныг нарийвчлан авч үзэх болно.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан орнуудын парламентын гишүүний халдашгүй байдлыг зохицуулж буй хуулиуд

Улс	Хууль зүйн үндэс	Хариуцлагаас чөлөөлөх (non-accountability) зохицуулалт	Халдашгүй байдлын (inviolability) зохицуулалт	Халдашгүй байдлаас чөлөөлөх журам	Онцлог
БНСУ	Үндсэн хууль, Үндэсний Ассамблейн тухай хууль	Танхим дотор хийсэн мэдэгдэл, өгсөн санал	Үндэсний Ассамблейн хуралдааны үеэр баривчилгаа, саатуулалтаас хамгаалах	Үндэсний Ассамблейн зөвшөөрөл	Сөрөг хүчний гишүүдийг хамгаалахад түүхэн ач холбогдолтой
БЭстУ	Үндсэн хууль, Парламентын (Riigikogu) дэгийн тухай хууль	Рийгикогу-ийн гишүүний хувиар илэрхийлсэн санал, өгсөн санал	Эрүүгийн хэрэг үүсгэхээс хамгаалах	Шүүхийн канцлерын санал болон Рийгикогугийн зөвшөөрлөөр	Нам харгалзахгүй эрх зүйн хяналт бүхий хоёр шатлалт тогтолцоо
ХБНГУ	Үндсэн хууль (Grundgesetz)	Бундестаг, эсхүл түүний байнгын хороодод хийсэн санал, мэдэгдэл	Эрүүгийн хариуцлага хүлээлгэх болон баривчлахаас хамгаалах	Бундестагийн зөвшөөрлөөр	Дархан эрх (immunity) ба нөхөн төлбөрийн хамгаалал (indemnity)-ыг ялган тогтоосон, тогтмол ашиглагддаг тодорхой журамтай

Япон	Үндсэн хууль, Парламентын тухай хууль	Танхимын дотор хэлсэн үг, хэлэлцүүлэг, өгсөн санал	Парламентын хуралдааны үеэр баривчилгаа, саатуулалтаас хамгаалах	Тухайн танхимын зөвшөөрөл	Дархан эрх нь түр хугацааны бөгөөд хууль тогтоох хуралдаантай холбоотой

Эх сурвалж: Судлаачийн ангилан боловсруулснаар.

Судалгааны нэгдүгээр бүлэг парламентын гишүүний (1) хариуцлагаас чөлөөлөх (non-accountability) зохицуулалтын харьцуулалт, (2) халдашгүй байдлын (inviolability) зохицуулалтын харьцуулалт гэх хоёр дэд бүлгээс бүрдэнэ. Дэд бүлэг тус бүрт харьцуулсан судалгаагаар сонгон авсан БНСУ, БНЭстУ, ХБНГУ, Япон Улсын хууль тогтоомж дахь зохицуулалтыг харьцууллаа.

1.2. Хариуцлагаас чөлөөлөгдөх (non-accountability) зохицуулалтын харьцуулалт

1.2.1. Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)

БНСУ-ын Үндсэн хуулийн 45 дугаар зүйлээр “Үндэсний Ассамблейн гишүүн танхимд албан ёсоор илэрхийлсэн үзэл бодол, өгсөн саналаараа танхимаас гадна хариуцлага хүлээхгүй” хэмээн зааж хариуцлагаас чөлөөлөх (non-accountability) зохицуулалтыг тусгасан байна.

Үндсэн хуулийн энэ зохицуулалттай холбоотойгоор Үндэсний ассамблейн тухай хууль, Үндэсний Ассамблейн Дотоод журам хүчин төгөлдөр үйлчилж байна. Үндэсний Ассамблейн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 4 дүгээр хэсэгт гишүүний үг хэлэхтэй холбоотой зохицуулалтыг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

Хүснэгт 2. БНСУ-ын Үндэсний Ассамблейн тухай хууль дахь гишүүний үг хэлэх эрхтэй холбоотой зохицуулалтууд[1]

Хуулийн зүйл, нэр	Зүйлийн агуулга
99 дүгээр зүйл. Үг хэлэх зөвшөөрөл	Гишүүн үг хэлэхийн тулд урьдчилан мэдэгдэж, даргын зөвшөөрөл авна.
100 дугаар зүйл. Үгээ үргэлжлүүлэх	Хуралдааны завсарлага, эсхүл тасалдах нөхцөл бий болсон ч, тухайн гишүүн эхэлсэн үгээ үргэлжлүүлэх эрхтэй.
101 дүгээр зүйл. Нэмэлт зохицуулалт	Хорооны дарга, эсхүл цөөнхийн төлөөлөгч тайланг нөхөж тайлбарлаж болно.
102 дугаар зүйл. Хэлэлцэж буй асуудалтай холбоогүй үг хэлэхийг хориглох	Хэлэлцэж буй асуудалд үл хамаарах үг хэлэхийг хориглоно.
103 дугаар зүйл. Үг хэлэх давтамжид хязгаар тогтоох	Нэг асуудлаар нэг гишүүн зөвхөн хоёр удаа үг хэлж болно (зарим тохиолдолд энэ зохицуулалт хамаарахгүй).
104 дүгээр зүйл. Үг хэлэх зарчим	Үг хэлэх хугацаа 15 минутаас хэтрэхгүй, нэмэлт болон няцаалт үүнээс богино хугацаатай байна.
105 дугаар зүйл. Таван минутын чөлөөт үг хэлэх	Чуулганы эхэнд гишүүн бүр 5 минутын чөлөөт үг хэлж санал бодлоо илэрхийлж болно.
106 дугаар зүйл. Хэлэлцүүлгийн тухай мэдэгдэл	Дэмжих, эсхүл эсэргүүцэх байр суурийг урьдчилан хуралдааны даргад мэдэгдэнэ.
106-2 дугаар зүйл. Филлибастер (filibuster) хэрэгжүүлэх	Нэг асуудлаар хугацааны хязгааргүй хэлэлцүүлэг өрнүүлэх эрх (дор хаяж 1/3 гишүүдийн гарын үсэг шаардлагатай).
107 дугаар зүйл. Хэлэлцүүлэгт даргын оролцоо	Дарга өөрөө хэлэлцүүлэгт оролцох бол суудлаа орхино. Санал хураалт дуусах хүртэл буцаж суудалдаа суухгүй.
108 дугаар зүйл. Асуулт, хэлэлцүүлгийг дуусгах	Хэлэлцүүлэг дууссан бол дарга дууссаныг зарлаж, санал хураалтад шилжүүлнэ.

Үндэсний Ассамблейн тухай хуульд гишүүн танхимд албан ёсоор илэрхийлсэн үзэл бодол болон өгсөн саналаараа танхимаас гадна хариуцлага хүлээхгүй байх зарчимтай холбогдсон дээрхээс өөр зохицуулалт байхгүй байна.

[1] БНСУ: (2020[2024]) Үндэсний Ассамблейн тухай хууль (National Assembly Act). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

1.2.2. Бүгд Найрамдах Эстони Улс (БНЭстУ)

БНЭстУ-ын парламентын гишүүний хариуцлагаас чөлөөлөгдөх (non-accountability) зохицуулалт нь Үндсэн хууль (62 дугаар зүйл)-д “Рийгикогугийн гишүүн нь мандатаар хязгаарлагдахгүй бөгөөд Рийгикогуд болон түүний харьяа байгууллагад өгсөн санал, гаргасан улс төрийн мэдэгдлийнхээ улмаас эрх зүйн хариуцлага хүлээхээс чөлөөлөгдөнө”[2] хэмээн тусгагдсан. Үүнийг Үндэсний парламентын гишүүний халдашгүй байдлын хүрээ, агуулгын нэг буюу парламентын гишүүний үг хэлэх эрх чөлөөг хамгаалах (хариуцлагаас чөлөөлөгдөх) зохицуулалт гэж үздэг (European Parliament, 2014). Үндсэн хуулийн зохицуулалтаас гадна Рийгикогугийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд парламентын гишүүний үг хэлэх эрх чөлөөтэй холбоотой зохицуулалтыг тусгасан байна.

Тухайлбал, суурь зохицуулалтын хувьд, Рийгикогугийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 17 дугаар зүйлд зааснаар “Рийгикогугийн гишүүд хараат бус байна. Тэд Үндсэн хууль, Рийгикогугийн баталсан хуулиуд, олон нийтийн ашиг сонирхол болон өөрийн ухамсар, итгэл үнэмшлийн дагуу ард түмнийг төлөөлөх үүргээ хэрэгжүүлнэ.”[3] Энэхүү үндсэн зарчмын хүрээнд парламентын гишүүний мандат бол “Үндсэн хууль, хууль тогтоомж, нийтийн ашиг сонирхол болон өөрийн ухамсар”-т нийцүүлэн хэрэгжүүлэх олон нийтийн өмнөх хариуцлага байна. Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Рийгикогугийн гишүүд нь Рийгикогуд буюу түүний аль ч байгууллагад өгсөн санал, гаргасан улс төрийн мэдэгдэлдээ хуулийн хариуцлага хүлээхээс чөлөөлөгдөнө” хэмээх гишүүний үг хэлэх эрх чөлөөтэй холбоотой зохицуулалтыг тусгасан байна.

1.2.3. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

Холбооны Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт парламентын гишүүний халдашгүй байдлыг тогтоож, Бундестаг болон түүний байнгын хороод дахь үг хэлэх эрх чөлөөг баталгаажуулсан байна. Уг зохицуулалт нь ХБНГУ-ын парламентын тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг[4] бөгөөд гишүүдийг эрүүгийн болон төрийн бусад хөндлөнгийн хяналт, хязгаарлалтаас хамгаалж, тэдний бие даасан байдлыг ханган, парламентын хэвийн үйл ажиллагааг хамгаалахад чиглэдэг. Үндсэн хуулийн зохицуулалтаар хариуцлагаас чөлөөлөх (indemnität) ба халдашгүй байдлыг (immunität) ялгаж өгснөөр энэ зохицуулалт нь халдашгүй байдлыг баталгаажуулж, улс төрийн шалтгаантай эрүүгийн ямар нэгэн хяналтаас сэргийлэх хамгаалалтыг бий болгодог[5] байна. Гэвч энэхүү хамгаалалтад тодорхой хязгаарууд байдаг. Үүнд: (1) гүтгэлгийн шинжтэй доромжлол” (verleumderische Beleidigungen) нь хариуцлагаас чөлөөлөх эрхийн хүрээнээс гадуур; (2) “гэмт хэрэг үйлдэж байхдаа баривчлагдсан” (auf frischer Tat ertappt) буюу гэмт хэрэг үйлдэж байхдаа саатуулагдсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжийг үлдээж[6] хамгаалалтын эрхийг хэрэгжүүлдэггүй.

Үг хэлэх эрхийн баталгааны хувьд Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Бундестагийн гишүүнийг ямар ч үед түүнийг Бундестагийн чуулганы нэгдсэн болон аль нэгэн байгын хорооны хуралдаан дээр өгсөн санал болон хэлсэн үгнийх нь төлөө шүүхийн болон албаных журмаар мөрдөн шалгах, мөн Бундестагаас гадуур ямар нэг байдлаар хариуцлагад татаж болохгүй. Энэхүү зохицуулалт бусдыг гүтгэн доромжлох үйлдэлд үйлчлэхгүй.

---

[2] БНЭстУ: Үндсэн хууль (The Constitution of the Republic of Estonia). Riigi Teataja. Хандах: https://www.riigiteataja.ee/en/eli/523042025002/consolide

[3] БНЭстУ: Рийгикогугийн гишүүний эрх зүйн байдлын тухай хууль (Status of Members of the Riigikogu Act). Riigi Teataja. Хандах: https://www.riigiteataja.ee/en/eli/516042015001/consolide

[4] Team Rechtswissen. “Art. 46 GG – Indemnität und Immunität der Abgeordneten (Kommentar): Grenzen der Indemnität: Bezug zur parlamentarischen Tätigkeit.” opinioiuris.de, September 24, 2024. Хандах: https://opinioiuris.de/kommentar/gg/46#Grenzen_der_Indemnitaet:_Bezug_zur_parlamentarischen_Taetigkeit

[5] Мөн тэнд.

[6] Мөн тэнд.

ХБНГУ-ын Үндсэн хууль дахь халдашгүй байдалд холбогдох зохицуулалтыг харвал 47 дугаар зүйлд “Бундестагийн гишүүн гишүүнийх нь хувьд түүнд хандан мэдээлэл өгсөн, эсхүл Бундестагийн гишүүн өөрөө тодорхой үйл баримтыг итгэмжлэн мэдээллэсэн этгээдийн тухай болон өөрөө тухайн үйл баримтын талаар гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй. Энэхүү гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг эдлэх үед тухайн асуудлын талаар бичигдсэн баримтыг хураан авахыг хориглоно” хэмээн заасан.

Энэхүү заалт нь “Indemnität” хэмээх зарчмыг илэрхийлдэг. Indemnität гэдэг нэр томьёо нь латин хэлний indemnitās (гэм хоргүй байдал, халдашгүй байдал) гэсэн үгнээс гаралтай. Энэ нь гишүүдийн парламентын үйл ажиллагаанд хамаарах санал болон үг хэллэгийг бүрэн хамгаалахыг баталгаажуулсан[7] зохицуулалт байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Indemnität) заасны хүрээнд Бундестагийн гишүүн өөрийн санал өгсөн, эсхүл танхим болон түүний байнгын хороодод хэлсэн үг, мэдэгдлийнхээ төлөө танхимаас гадна хариуцлага хүлээхгүй. Үндсэн хуулийн энэ заалтад тусгагдсан чухал хязгаарлалт нь “гүтгэлгийн шинжтэй доромжлолд энэ дархан эрх хамаарахгүй” гэх заалт байна. Энэ нь хууль тогтоох байгууллагын доторх үг хэлэх эрх чөлөө чухал боловч зориудын, худал доромжлол нь хамгаалалтын гадна үлдэх ёстой болохыг Үндсэн хууль хүлээн зөвшөөрснийг харуулдаг. Ингэснээр гишүүд парламентын үйл ажиллагаагаа хувийн айдас, эрүүгийн, эсхүл захиргааны хариуцлага, эсхүл улс төрийн шахалтгүйгээр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ. Мөн энэ хамгаалалт нь орчин үеийн парламентын тогтолцооны суурь механизмын нэг бөгөөд эрх, үүргээ чөлөөтэй хэрэгжүүлэх үндэс болдог.[8] Мөн улс төрийн маргаан өргөн хүрээнд, хязгаарлалтгүй явагдаж, парламентын үйл ажиллагаа чөлөөтэй явагдах нөхцөлийг бүрдүүлдэг.[9] Халдашгүй байдлын зохицуулалт нь санал хураалт болон үг хэлэхэд хамаарна. Энэ хүрээ нь зөвхөн парламентын үйл ажиллагаанд (Бундестаг болон түүний хороодод) хамаарах бөгөөд парламентын гадна илэрхийлсэн мэдэгдэлд хамаарахгүй. Хамгаалалтад парламент дахь бүх хэлбэрийн оролцоо багтана. Үүнд:

- илтгэл, хэлэлцүүлэгт оролцох;
- завсарлага (Sitzungsunterbrechung/Sitzungspause) үед санал, бодлоо илэрхийлэх;
- бичгээр санал гаргах;
- парламентын мэтгэлцээн оролцох хамаарна.

Дээрх хэлбэрээс харахад, халдашгүй байдлын хамгаалалт хязгаар нь зөвхөн парламентын үйл ажиллагаатай шууд холбоотой санал, илэрхийлэлд хамаарна. Гишүүний хувийн орон зайд хийсэн үйлдэл, эсхүл парламентын гадна болсон улс төрийн арга хэмжээ, хэвлэлийн нийтлэл, илтгэл зэрэгт энэ хамгаалалт хамаарахгүй. Харин хугацааны хувьд “ямар ч үед” (zu keiner Zeit) хүчинтэй тул гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа ч түүний ажиллаж байх үед өгсөн санал, илэрхийлэл нь хожим эрүүгийн хариуцлагад татах боломж, үндэслэл болохгүй.[10]

Үндсэн хуулийн дээрх зохицуулалтыг дараах хууль тогтоомжоор баталгаажуулсан. Үүнд:

- Бундестагийн Дотоод журам (Geschäftsordnung des Bundestages);
- Бундестагийн халдашгүй байдлын тухай тогтоол байна.

Нэгдүгээрт, Бундестагийн Дотоод журам (Geschäftsordnung des Bundestages)-ийн 107 дугаар дүрэм болон 6 дугаар хавсралтад парламентын халдашгүй байдал, хариуцлагаас ангид байхтай холбоотой журам, “Бундестагийн гишүүдийн халдашгүй байдлыг хасах тухай

[7] Team Rechtswissen. “Art. 46 GG – Indemnität und Immunität der Abgeordneten (Kommentar): Grenzen der Indemnität: Bezug zur parlamentarischen Tätigkeit.” opinioiuris.de, September 24, 2024. Хандах: https://opinioiuris.de/kommentar/gg/46#Grenzen_der_Indemnitaet:_Bezug_zur_parlamentarischen_Taetigkeit
[8] Мөн тэнд.
[9] Мөн тэнд.
[10] Мөн тэнд.

шийдвэр", мөн "Халдашгүй байдлын асуудлыг зохицуулах зарчим"-ыг тус тус зааж өгсөн байна.

Хоёрдугаарт, Бундестагийн халдашгүй байдлын тухай тогтоолыг Бундестаг баталдаг бөгөөд халдашгүй байдлыг хасах журам, мөн тухайн тохиолдолд мөрдөх зарчмуудыг нарийвчлан тогтоодог байна. Дээрх дүрэм болон тогтоолыг парламентын бүрэн эрхийн хугацаа бүрийн эхэнд чуулган болон 1 дүгээр хороо баталж, Бундестагийн дотоод журмын 6 дугаар хавсралтад хамтад нь нийтэлдэг. Энэ тогтоол нь гишүүний үг хэлэх эрхийн хамгаалалтаас илүүтэй Бундестагийн гишүүдийн халдашгүй байдлыг хэрхэн, ямар нөхцөлд түдгэлзүүлж болох, мөн мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх, мэдээлэх, түдгэлзүүлэх журмыг тодорхойлсон байна.

Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрт "Энэ нь гүтгэлгийн шинжтэй доромжлолд (verleumderische Beleidigungen) хамаарахгүй" хэмээн заасан.[11] Энэ заалт нь халдашгүй байдлын (Indemnität)-ийн үндсэн зарчмын чухал хэсэг байна. Тухайлбал, хэрвээ Бундестагийн гишүүн санаатай худал мэдээлэл тарааж, бусдыг гутаан доромжлох зорилготой бол халдашгүй байдлын хамгаалалт үйлчлэхгүй. Харин хурцадмал улс төрийн маргааны үеийн шүүмжлэл үүнд хамаарахгүй бөгөөд халдашгүй байдлын (Indemnität)-ийн зохицуулалт үйлчилсээр байна.

Түүнчлэн ХБНГУ-ын Эрүүгийн хууль (StGB)-ийн §185–187 нь доромжлол, гүтгэлэг, худал мэдээллийг ялган зохицуулдаг. Ялангуяа Эрүүгийн хуулийн §187 дугаар зүйлд санаатайгаар гүтгэх буюу "Хүний нэр хүндийг гутаах, түүнтэй холбоотойгоор олон нийтийн санаа бодолд сөргөөр нөлөөлөх, эсхүл нэр хүндийг нь алдагдуулахуйц худал мэдээллийг санаатайгаар, ухамсартайгаар мэдэгдсэн буюу тараасан этгээдийг хоёр жил хүртэлх хугацаагаар хорих ял, эсхүл мөнгөн торгууль оногдуулна. Хэрэв уг гэмт хэргийг олон нийтийн өмнө, хурал дээр, эсхүл бичгээр тараасан бол таван жил хүртэлх хугацаагаар хорих ял, эсхүл мөнгөн торгууль оногдуулна"[12] заасны хүрээнд худал баримтыг санаатай тараасан үйлдлийг гүтгэлэг гэж үзэж хорих, мөнгөн торгууль оногдуулах зохицуулалттай байна. Тиймээс гишүүдийн санаатай худал мэдээлэлд суурилж гүтгэх, гутаан доромжилсон үйлдэлд халдашгүй байдлын (Indemnität)-д хамгаалалт үйлчлэхгүй бөгөөд тэднийг иргэний (хохирол, нөхөн төлбөр) болон эрүүгийн журмаар хариуцлагад татах зохицуулалт үйлчилдэг.

Мөн Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй (үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан заалт) харилцан уялдаатай бөгөөд зөрчилдөөн үүсдэг. Үндсэн хуулийн 5 дугаар зүйл нь иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалдаг бол Үндсэн хуулийн 46 дугаар зүйл нь парламентын гишүүдийн парламентын үйл ажиллагаанд оролцохтой холбогдсон үзэл бодлоо илэрхийлэх эрхийг онцгойлон хамгаалдаг. Гэвч парламентын орчин дахь хамгаалалтын шаардлагууд нь гишүүдийн тусгай үүргийн улмаас илүү хатуу тул халдашгүй байдал нь энэ хүрээнд Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд заасан ерөнхий хамгаалалтаас өргөн цар хүрээгээр үйлчилдэг. Гүтгэн доромжлох (verleumderische Beleidigungen), эсхүл зориудын худал мэдээлэл түгээх үед халдашгүй байдлын хамгаалалт хэрэгжихгүй байгаа нь парламентад хүлээлгэсэн итгэл болон эрх чөлөөг бусдад хор хохирол учруулахад ашиглахгүй байх, гишүүний мандатын хамгаалалт

[11] ХБНГУ: "Basic Law for the Federal Republic of Germany (Grundgesetz)" (2019[2025]). Gesetze im Internet. §46.1. Хандах: https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html

[12] ХБНГУ: "Criminal Code (StGB)" (2021). Gesetze im Internet. §187. Хандах: https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html

ба бусдын нэр төр, хувийн эрхийн хооронд зохистой тэнцвэрийг бий болгох[13] үндсэн үзэл баримтлалтай байна.

1.2.4. Япон Улс

Япон Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлд заасан “хариуцлагаас чөлөөлөх зохицуулалт”-ыг харвал, “Үндэсний парламент (National Diet)-ын Төлөөлөгчдийн танхим болон Зөвлөхүүдийн танхимын гишүүд нь танхим дотор хэлсэн үг, хийсэн мэтгэлцээн, өгсөн саналтай нь холбоотойгоор танхимаас гадна хариуцлага хүлээхгүй”[14] гэж заасан. Энэ зохицуулалт нь хууль тогтоогчид төлөөллийн болон хууль тогтоох чиг үүргээ ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай илэрхийлэх эрх чөлөөгөөр ханган хэрэгжүүлэх боломжийг олгох зохицуулалт буюу туйлын хамгаалалт байна.

Үндсэн хуулийн энэ зохицуулалтын үйлчлэх хүрээний хязгаарлалтыг “Үндэсний парламентын тухай хууль (National Diet Act)-ийн 14 дүгээр бүлэгт гишүүний сахилга бат хэсэгт хуульчилсан. Тухайлбал, хуулийн 119 дүгээр зүйлд “Гишүүн бусдыг доромжилсон хэллэг хэрэглэх, хувийн амьдралд хамаарах яриа өрнүүлэхийг хориглоно” гэж 120 дугаар зүйлд “Чуулганы хуралдаан болон хорооны хуралдаан дээр доромжлол үйлдсэн гишүүнд сахилгын шийтгэл ногдуулахаар танхимд гомдол гаргаж болно” хэмээн тус тус заасан.[15]

Зөвлөхүүдийн танхимын дүрмийн хувьд 4 дүгээр дэд бүлэгт гишүүдийн “үг хэлэх”-тэй холбоотой асуудлыг зохицуулсан. Япон Улсын хувьд, парламентын гишүүний хэлсэн үгэндээ хариуцлага хүлээхгүй байх зарчим нь хоёр түвшний тогтолцоог хамаарна. Нэгдүгээрт, Үндсэн хуульд баталгаажсан халдашгүй байдал нь гишүүнийг шүүхийн маргаанд орохоос бүрэн хамгаалдаг бөгөөд чөлөөтэй мэтгэлцэх орчныг бүрдүүлдэг. Хоёрдугаарт, энэ эрх чөлөө нь Үндэсний парламент өөрийнх нь дотоод журам, сахилгын шийтгэл, шүүхийн практик, ёс зүйн хяналтаар зохицуулагдаж, эрх мэдлийг урвуулан ашиглахыг хязгаарладаг, ялангуяа цахим орчинд илүү нарийн хяналт тогтоодог байна.

[13] Team Rechtswissen. “Art. 46 GG – Indemnität und Immunität der Abgeordneten (Kommentar): Grenzen der Indemnität: Bezug zur parlamentarischen Tätigkeit.” opinioiuris.de, September 24, 2024. Хандах: *https://opinioiuris.de/kommentar/gg/46#Grenzen_der_Indemnitaet:_Bezug_zur_parlamentarischen_Taetigkeit*

[14] Япон Улс: Үндсэн хууль (The Constitution of Japan) Хандах: *https://japan.kantei.go.jp/constitution_and_government_of_japan/constitution_e.html*

[15] Япон Улс: Япон Улсын Үндэсний парламентын тухай хууль (National Diet Law). Хандах: *https://laws.e-gov.go.jp/law/322AC1000000079#Mp-Ch_14-At_118_2*

1.3. Халдашгүй байдлын (inviolability) зохицуулалтын харьцуулалт

1.3.1. Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)

БНСУ-ын хууль тогтоох байгууллагын гишүүдийн дархан эрх, халдашгүй байдалд холбогдох зохицуулалт нь 1987 оны Үндсэн хуульд хуульчлагдсан бөгөөд энэ нь ардчилсан хөдөлгөөний үр дүнд бий болсон цэргийн дарангуйллын дэглэмийг халсантай шууд холбоотой зохицуулалт байна. Уг Үндсэн хууль нь хууль тогтоогчдод хоёр чиглэлээр эрх зүйн баталгаа олгосон байдаг. Үүнд: нэгдүгээрт, хуралдааны хугацаанд гишүүнийг дур мэдэн баривчлах, саатуулах ажиллагаанаас хамгаалах халдашгүй байдал, хоёрдугаарт, Үндэсний Ассамблейн үйл ажиллагааны хүрээнд хэлсэн үг болон өгсөн саналтай холбоотойгоор эрүүгийн болон иргэний хариуцлага хүлээлгэхээс чөлөөлөх эрх байна.

Зохицуулалт нь Үндсэн хуулийн 44 ба 45 дугаар зүйлд тусгагдсан ба хариуцлагаас чөлөөлөх (non-accountability) болон халдашгүй байх (inviolability) гэсэн хос системийг хуульчилсан. Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Үндэсний Ассамблейн чуулганы үед, хэргийн газар дээр баригдсан тохиолдлоос бусад нөхцөлд, Үндэсний Ассамблейн зөвшөөрөлгүйгээр гишүүнийг баривчлах, саатуулахыг хориглоно” гэж, 2 дахь хэсэгт “Чуулган эхлэхээс өмнө гишүүнийг баривчилсан, эсхүл саатуулсан бол, хэргийн газар дээр баригдсан нөхцөлөөс бусад тохиолдолд, Үндэсний Ассамблейн шаардлагын дагуу тухайн гишүүнийг чуулганы хугацаанд суллана” хэмээн халдашгүй байх (inviolability)-ыг зохицуулсан байна.[16]

Үндсэн хуулийн энэхүү зохицуулалтаас гадна Үндэсний Ассамблейн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт Үндэсний Ассамблейн гишүүдийг зөвшөөрөлгүйгээр гишүүнийг баривчлах, саатуулахыг хориглох зохицуулалтыг[17], мөн Цэргийн тухай хуулийн 13 дугаар зүйлд Үндэсний Ассамблейн гишүүдийн баривчлагдахаас ангид байх эрхийг[18] тус тус зохицуулсан байна. Үүнээс Үндэсний Ассамблейн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн зүйл заалтууд дараах байдлаар хуульчлагдсан байна. Үүнд:

Хүснэгт 3. БНСУ-ын Үндэсний Ассамблейн тухай хууль дахь гишүүний халдашгүй байдалд холбогдох зохицуулалт

Хуулийн зүйл заалт	***Зүйлийн товч утга***
24 дүгээр зүйл (Тангараг өргөх):	*Гишүүн бүр бүрэн эрхийн хугацааны эхэнд Үндсэн хуулийг сахих, ард түмний эрх чөлөө, сайн сайхан байдлыг хамгаалах, улсын ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих, үүргээ үнэнчээр биелүүлэхээ тангараглана.*
25 дүгээр зүйл (Нэр төрөө сахих үүрэг):	*Гишүүн Ассамблейн гишүүний ёс зүй, нэр төрийг хадгална.*
26 дүгээр зүйл (Баривчлах зөвшөөрөл хүсэх журам):	*Гишүүнийг баривчлахын тулд шүүх Засгийн газраар дамжуулан Ассамблейгаас зөвшөөрөл хүснэ. Ассамблейд мэдэгдсэний дараа 24–72 цагийн дотор санал хураалт явуулна.*
27 дүгээр зүйл (Үндэсний Ассамблейн гишүүнийг баривчилсны тухай мэдэгдэх):	*Гишүүнийг баривчилсан, эсхүл саатуулсан тохиолдолд Засгийн газарт даруй мэдэгдэнэ. Саатуулах хугацаа сунгасан бол мөн адил мэдэгдэнэ.*

[16] БНСУ: Үндэсний Ассамблей (1987). “Constitution of the republic of Korea”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1
[17] БНСУ: Үндэсний Ассамблей (2020). “National Assembly Act”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG
[18] БНСУ: Үндэсний Ассамблей (1981[2017]). “Martial law”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=45785&type=part&key=13

28 дүгээр зүйл (Суллах хүсэлт гаргах журам):	*Гишүүнийг суллуулах хүсэлтийг Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн 1/4 нь гарын үсэг зурж, Ассамблейн даргад өргөн мэдүүлнэ.*
29-2 дүгээр зүйл (Ашгийн төлөө бизнес эрхлэхийг хориглох):	*Гишүүн албан үүргээсээ гадуур бизнес эрхлэхгүй. Харин өөрийн хөрөнгө (жишээ нь, түрээс) ашиглах бол зөвшөөрөгдөнө. Бусад бизнесийг сонгогдсоноос хойш 6 сарын дотор хаах ёстой. Өөрийн бизнесийн хэрхэн шийдвэрлэсэн талаар тайлагнах ба ёс зүйн хорооны дүгнэлт шаардлагатай.*
30 дүгээр зүйл (Цалин хөлс, аяллын зардал гэх мэт):	*Гишүүн хуульд заасны дагуу цалин, аяллын зардал авна.*

Эх сурвалж: Судлаачийн ангилан боловсруулснаар.

Үндэсний Ассамблейн тухай хуулийн дээрх зохицуулалтаас эрүүгийн болон иргэний хариуцлагаас чөлөөлөх зохицуулалт нь 4 дүгээр бүлгийн 26-28 дугаар зүйлд хуульчлагдсан байна.[19] Зохицуулалт бүрийг дэлгэрүүлэн авч үзвэл:

Үндэсний Ассамблейн тухай хуулийн 2018 оны шинэчлэн найруулгын 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хэргийг харьяалах шүүхийн шүүгч нь Үндэсний Ассамблейн гишүүнийг баривчлах, эсхүл саатуулахын тулд Ассамблейн зөвшөөрөл авах шаардлагатай бол баривчлах шийдвэр гаргахаасаа өмнө Засгийн газарт хүсэлт гаргана. Засгийн газар уг хүсэлтийг хүлээн авч хуулбарын хамтаар даруй Үндэсний Ассамблейд уламжилна” хэмээгээд 2 дахь хэсэгт “(1)-д заасан баривчлах зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авсны дараа Ассамблейн дарга асуудлыг хамгийн түрүүнд хуралдсан чуулганд танилцуулна. Энэ хүсэлтийг танилцуулснаас хойш дор хаяж 24-72 цагийн дотор санал хураалтыг явуулна. Хэрэв 72 цагийн дотор санал хураагаагүй бол дараагийн чуулганы хэлэлцэх асуудлын эхэнд оруулж, санал хураалт явуулна” хэмээн заасан байна.

Хуулийн 27 дугаар зүйлд “Үндэсний Ассамблейн гишүүнийг баривчилсан тухай мэдэгдэх”-ийг хуульчилсан. Энэ заалтын хүрээнд Үндэсний Ассамблейн гишүүнийг баривчилсан, эсхүл саатуулсан тохиолдолд Засгийн газар баривчилсан буюу саатуулсан тухай болон баривчлах тогтоолын хуулбарыг даруй Ассамблейн даргад мэдэгдэнэ. Саатуулах хугацаа сунгасан тохиолдолд мөн адил мэдэгдэнэ.

Хуулийн 28 дугаар зүйлд “Гишүүнийг суллах хүсэлт гаргах журам”-ыг хуульчилсан. Энэ заалтын хүрээнд хэрвээ Үндэсний Ассамблейн гишүүд баривчлагдсан, эсхүл саатуулагдсан гишүүнийг суллах санал дэвшүүлбэл, нийт бүртгэлтэй гишүүдийн дор хаяж 1/4 нь хамтран гарын үсэг зурсан суллах хүсэлтийг суллах шалтгааны хамт Ассамблейн даргад өргөн мэдүүлэх ёстой.

Харин БНСУ-ын Цэргийн тухай хуулийн 13 дугаар зүйл Үндэсний Ассамблейн гишүүдийн баривчлагдахаас ангид байх эрхийг “Цэргийн байдал зарлагдсан үед ч Үндэсний Ассамблейн гишүүдийг гэмт хэргийн үйлдэл дээр нь баривчлахаас бусад тохиолдолд баривчлах буюу саатуулахыг хориглоно” хэмээн хуульчилсан.[20]

БНСУ-ын Үндсэн хууль судлаачдын хүрээнд парламентын гишүүний эрүүгийн болон иргэний хариуцлагаас чөлөөлөх зохицуулалт, халдашгүй эрхийн тухай тайлбар нь үндсэндээ гурван онолын чиглэлд хуваагдаж тайлбарлагдаж байна. Үүнд: (1) абсолют эрхийн онол, (2) парламентын онол болон (3) эвлэрлийн онол (Kim, 2020) байна.

Түүнчлэн Үндсэн хууль болон хууль тогтоомжийн судлаачид (тухайлбал, профессор Сон Жун-Ён, Ким Хён-Нам нар) парламентын гишүүний халдашгүй байдалтай холбоотой дээрх

[19] БНСУ: Үндэсний Ассамблей (2020). “National Assembly Act”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG
[20] БНСУ: Үндэсний Ассамблей (1981[2017]) “Martial law”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=45785&type=part&key=13

заалтыг эрх мэдэл хуваарилалтын зарчмын “цөм илрэл” гэж тайлбарласан (Song Joong-Young, 2011) байдаг. Дээрх судлаачид парламентын гишүүнийг саатуулахын тулд заавал хууль тогтоох байгууллагын зөвшөөрөл шаардлагатай байдаг нь шүүх эрх мэдэл, эсхүл шүүх ба гүйцэтгэх эрх мэдэл хамтран хууль тогтоох байгууллагын эрх мэдлийг нэг талыг барьсан байдлаар хязгаарлах боломжийг хаадаг. Ийм процедур нь “Үндэсний Ассамблейн бие даасан байдал, хууль тогтоох үйл ажиллагааны эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн бөгөөд ямар ч нөхцөлд үл хязгаарлагдана” хэмээн (Song Joong-Young, 2011) тайлбарласан.

Түүнчлэн эрүүгийн болон иргэний хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтын процедурын хувьд уг заалт нь баривчлах зөвшөөрлийн асуудлыг хэлэлцэхэд 72 цагийн дээд хугацаа тогтоосон. Судлаачдын үзэж буйгаар энэ нь парламентын эрх мэдлийг урвуулан хэрэглэх, эсхүл санал хураалтыг зориуд хойшлуулснаас болж шүүх ажиллагаа удаашрах эрсдэлээс сэргийлдэг (Song Joong-Young, 2011). Ёнсэ (Yonsee)-гийн их сургуулийн хууль зүйн профессор Ким Жон-Чолын тайлбарласнаар, “санал хураалтын хугацаа тогтоосон нь шүүхийн яаралтай (хойшлуулахгүй) ажиллагаа ба хууль тогтоох байгууллагын хэлэлцүүлгийн хоорондын тэнцвэрийг хангаж өгдөг. Хэрэв уг хугацааг хэтрүүлбэл дараагийн нэгдсэн чуулганы эхний хэлэлцэх асуудал болгон заавал хэлэлцэх ёстой. Энэ нь процедурын шуурхай, ил тод байдлыг хангаж өгөх зохицуулалт” (Jong-Chul, 2024) байна.

Ердийн үед Үндэсний Ассамблейн гишүүний баривчлагдахаас ангид байх халдашгүй эрх нь зөвхөн чуулганы хугацаанд болон хэрэв гишүүн үйлдэл дээрээ баригдаагүй тохиолдолд хэрэгжинэ. Хэрэв чуулган эхлэхээс өмнө гэмт хэрэг үйлдэж, шүүхээс баривчлах зөвшөөрөл олговол чуулганы хугацаанд ч баривчлагдахаас ангид байх эрх хүчинтэй хэвээр байна. Жишээ нь хэрвээ чуулганы үеэр хүн амины хэрэг үйлдвэл халдашгүй эрх үйлчлэхгүй (үйлдэл дээрээ баригдсан тохиолдолд), баривчлах боломжтой гэсэн үг. Гэхдээ энэ тохиолдлын сул тал нь мөрдөн шалгах байгууллага нь тухайн гишүүнийг гэмт хэрэгтэн гэж үзэж, эсхүл чуулганы завсарлагааг ашиглан баривчилж болно. Энэ тохиолдолд Үндэсний Ассамблей баривчлах зөвшөөрлийн тогтоолыг санал хураалтаар баталбал, чуулганы үеэр ч баривчилж болно. Гэхдээ ийм тохиолдол маш ховор бөгөөд БНСУ-ын Үндсэн хуулийн түүхэнд ердөө 18 удаа л тохиож байсан (Хүснэгт 6). Үндэсний Ассамблейн баривчлах зөвшөөрлийн тогтоол батлагдсан ч энэ нь заавал баривчилгаа болно гэсэн үг биш. Энэ нь зөвхөн шүүхэд баривчлах зөвшөөрлийг дахин хэлэлцэх боломжийг олгох ба шүүх зөвшөөрлийг үгүйсгэвэл баривчилгаа хэрэгжихгүй гэсэн үг.

Үйлдэл дээрээ баригдсан гишүүнийг баривчлах тухай асуудал нь Үндэсний Ассамблейн тухай хуулийн 150 дугаар зүйлд заагдсан байдаг. Тухайлбал, Үндэсний Ассамблейн тухай хуулийн 150 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндэсний Ассамблейн дотор гэмт үйлдэл дээрээ баригдсан этгээд байвал, хамгаалалтын албан хаагч, эсхүл цагдаагийн албан хаагч түүнийг заавал баривчилж, дараа нь Ассамблейн даргын зааврыг хүлээнэ. Гэвч, Үндэсний Ассамблейн танхимд даргын зөвшөөрөлгүйгээр гишүүнийг баривчилж болохгүй” хэмээн заасан. Чуулганы завсарлагааны үед гишүүнийг баривчилж болно. Гэвч чуулган эхлэхэд Ассамблейн хүсэлтээр түүнийг суллах ёстой. Гишүүдийг зөвхөн албан ёсны шүүхийн шийдвэрээр, хүнд шийтгэл оноосон тохиолдолд баривчилж, хорих боломжтой. Хэрвээ гишүүнд 1 сая воноос дээш торгууль ногдуулбал, эсхүл Сонгуулийн тухай хууль болон Төрийн албан тушаалтны тухай хууль зөрчсөн нь тогтоогдвол, тухайн гишүүн эрүүгийн хариуцлага хүлээж, Үндэсний Ассамблейн гишүүний суудлаа автоматаар (сонгуулийн хүчингүй болох) алдана.

БНСУ-ын Үндэсний Ассамблейн судалгааны албанаас гаргасан “Парламентын мэдээллийн эмхэтгэл (Анхдугаар Үндсэн хуульт Үндэсний Ассамблей ~ 21 дүгээр Үндэсний Ассамблей)”-д (South Korea: National Assembly, 2025) 1948 оноос 2024 он хүртэлх гишүүний халдашгүй байдалд холбогдох статистикийг мэдээллэснийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4. БНСУ-ын Үндэсний Ассамблейн гишүүдийн баривчлах, саатуулах зөвшөөрөлд холбогдох статистик (1948-2024 он)

Дугаар (Үндэсний Ассамблей) (бүрэн эрх эхэлсэн он)	**Гишүүнийг баривчлах, саатуулах тухай санал өргөн мэдүүлсэн**	**Саналыг шийдвэрлэсэн байдал**				
	(Гишүүдийн 4/1)-аар өргөн мэдүүлсэн тоо	Баталсан	Буцаасан	Хэрэгсэхгүй болгосон	Өргөдлөө татсан	Бүрэн эрх дууссанаар хүчингүй болсон
Түр (Анхдугаар, 1948)	1	1	-	-	-	-
2 дахь (1950)	1	1	-	-	-	-
3 дахь (1954)	2	1	1		-	-
4 дэх (1960)	6	3	1	2	-	-
5 дахь (1963)	1	1			-	-
6 дахь (1967)	1		1		-	-
7 дахь (1967)	-	-	-	-	-	-
8 дахь (1971)	-	-	-	-	-	-
9 дэх (1973)	-	-	-	-	-	-
10 дахь (1978)	-	-	-	-	-	-
11 дэх (1981)	-	-	-	-	-	-
12 дахь (1985)	1	1		-	-	-
13 дахь (1988)	1		1	-	-	-
14 дэх (1992)	1	1	-	-	-	-
15 дахь (1996)	12	1	2	-	-	9
16 дахь (2000)	15	7	6	2	-	-
17 дахь (2004)	1	-	1		-	-
18 дахь (2008)	3	1	–	2	-	-
19 дэх (2012)	11	4	2	2	2	3
20 дахь (2016)	5	-	2	-	-	3
21 дэх (2020)	9	5	4	-	-	-
22 дахь (2024)	-	-	-	-	-	-
Нийт	**71**	**18**	**20**	**14**	**4**	**15**

Эх сурвалж: Парламентын мэдээллийн эмхэтгэл (Анхдугаар Үндсэн хуульт Үндэсний Ассамблейгээс ~ 21 дүгээр Үндэсний Ассамблей хүртэл)”

Дээрх хүснэгтээс харахад, 1948 оноос хойш нийт 71 удаа баривчлах зөвшөөрлийн санал гишүүдээс өргөн мэдүүлэгдсэн байна. Үүнээс: 18 нь батлагдсан (25.4%), 20 нь буцаагдсан (28.2%), 14 нь хэрэгсэхгүй болсон, 4 нь өргөдлөө эргүүлэн татсан, 15 нь парламентын бүрэн эрхийн хугацаа дууссанаар хүчингүй болсон байна (South Korea: National Assembly, 2025). Дээрх үзүүлэлтээс 7-11 дүгээр Үндэсний Ассамблейн бүрэн эрхийн хугацааны үед нэг ч санал өргөн мэдүүлээгүй нь тухайн үеийн улс төрийн дэглэм, хууль хяналтын байгууллагын хараат бус байдал сул байсантай холбоотой хэмээн тайлбарлагдаж байна. Харин 15-16 дугаар бүрэн эрхийн хугацаанд хамгийн олон санал (нийт 27) өргөн мэдүүлэгдсэн бөгөөд энэ нь тухайн үеийн авлигын эсрэг хийгдсэн мөрдөн шалгах ажиллагаа, улс төрийн хурц тэмцлийн илэрхийлэл гэж тооцогддог. Нийт хугацаа дахь Үндэсний Ассамблейн шийдвэрийг тоймлон харвал, буцаагдсан санал батлагдсанаас илүү тохиолдсон нь парламентын гишүүд ихэнхдээ хамт олноороо бие биенийгээ хамгаалах институцийн соёл давамгайлж байсныг илтгэнэ. Хугацаа дууссанаар хүчингүй болсон тохиолдлууд их байсан нь парламент асуудлыг санаатайгаар хойшлуулж, цаг хугацааны хүчин зүйл ашиглан гишүүдийг хууль хяналтын ажиллагаанаас хамгаалж ирснийг харуулж байна.

Европын зарим улс (жишээ нь: Герман, Франц) парламентын гишүүдийн баривчлах зөвшөөрлийг шийдэхдээ тусгай байнгын хороонд төвлөрүүлж, улс төрийн сэдлээр хамгаалалт үзүүлэхээс зайлсхийдэг бол БНСУ-ын хувьд ийм асуудлыг олон нийтэд ил тод хэлэлцдэг.

Үндэсний Ассамблейн гишүүнийг баривчлах зөвшөөрөл хүсэх журамд холбогдох зохицуулалт нь Үндэсний Ассамблейн тухай хуулийн 8 дугаар зүйлд Үндэсний Ассамблейн гишүүнийг баривчлах зөвшөөрөл хүсэх тухай (1) Шүүх, эсхүл шүүгч нь сэжигтэн, яллагдагч, эсхүл гэрч бөгөөд Үндэсний Ассамблейн гишүүнд холбогдуулан баривчлах, эсхүл цагдан хорих шийдвэр гаргахыг хүсвэл, Үндэсний Ассамблейн тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу баривчлах зөвшөөрлийн хүсэлт гаргаж, дараа нь баривчлах шийдвэр гаргах ёстой. Энэ хүсэлтийг [Автомат маягт B1500]-ын дагуу илгээх бөгөөд үүнд, "баривчлах" гэдэг нь Үндэсний Ассамблейн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан “баривчлах, саатуулах, цагдан хорих” гэсэн утгыг агуулна. Хүсэлтийг холбогдох прокурорын газар, эсхүл мөрдөн шалгах байгууллагад илгээх ёстой. Гэхдээ дараах тохиолдолд энэ журам хамаарахгүй байна. Үүнд (Namuwiki, 2025):

1. баривчлах зөвшөөрөл хүссэний дараа гаргасан баривчлах шийдвэр дээр үндэслэсэн тохиолдолд;
2. гэмт үйлдэл дээрээ баригдсан этгээдийн баривчилгааны хүсэлт;
3. Эрүүгийн хуулийн 201-2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу баривчлах шийдвэр гаргасан тохиолдол (Шүүгч нь мөрдөн шалгах сонсгол хийх цаг, газрыг прокурор, сэжигтэн болон түүний өмгөөлөгчид мэдэгдэх ёстой).

   (1) Сэжигтнийг баривчилсны дараа хорих зөвшөөрөл хүсвэл, шүүгч нь маргаашийн дотор багтаан түүнийг байцаах ёстой. (2) Бусад тохиолдолд, хэрэв сэжигтэн гэмт хэрэг үйлдсэн байх үндэслэлтэй бол шүүгч нь саатуулж байцаана. Харин сэжигтэн оргон зайлсан, эсхүл байцаах боломжгүй бол энэ журам үйлчлэхгүй. Энэ үед, хэрэв сэжигтэн аль хэдийн баривчлагдсан байвал прокурор нь түүнийг сонсголд оролцуулахаар авч ирэх үүрэгтэй.[21]

   (2) баривчлах зөвшөөрөл хүсэхдээ, яллагдагч, эсхүл гэрчийг цагдан хорихоос өмнө хүсэлт гаргах тохиолдолд тухайн хүсэлтийн шийдвэр гарах огноо, цагийг тэмдэглэн заавал бүртгэх ёстой. Тухайлбал огнооны жишээ нь:
   - баривчлах хүсэлт 2003 оны 11 сарын 5-нд өргөн баригдсан бол, 2003 оны 11 сарын 7-нд 15:00 цагт шийдвэрлэх;
   - баривчлах хүсэлт 2003 оны 11 сарын 12-15-ны хооронд өргөн баригдсан бол, 2003 оны 11 сарын 17-нд 16:00 цагт шийдвэрлэх;
   - баривчлах хүсэлт 2003 оны 11 сарын 20-26-ны хооронд өргөн баригдсан бол, 2003 оны 11 сарын 28-нд 15:00 цагт шийдвэрлэх гэх мэт бичигдсэн байна.
4. Баривчлах зөвшөөрөл хүсэх нь зайлшгүй шаардлагатай гэж үзвэл, нэмэлт баримт бичгийг прокурорын газар, мөрдөн шалгах байгууллага, эсхүл холбогдох байгууллагад илгээж болно.

БНСУ-ын 20 болон 21 дэх удаагийн Үндэсний Ассамблейн хугацаанд хэлэлцсэн болон шийдвэрлэн гишүүний халдашгүй байдалтай холбоотой статистикийг (South Korea: National Assembly, 2025) доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5. БНСУ-ын Үндэсний Ассамблейн гишүүдийн баривчлах зөвшөөрлийн талаарх санал, шийдвэрийн статистик тойм

Дугаар (Үндэсний Ассамблей)	Хэлэлцсэн асуудлын утга	Саналыг гаргасан этгээд (саналын өдөр)	Хэлэлцсэн Үр дүн	Агуулга

[21] БНСУ: Үндэсний Ассамблей (2009). “Criminal Procedure Act”. Хандах: South Korea: National Assembly (2020) “Martial law”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=45785&type=part&key=13

20 дахь	Гишүүн Жон Гён Хван баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2017.12.12)	Хэрэгсэхгүй болгосон	Тусгай эдийн засгийн гэмт хэргийн тухай хууль зөрчсөн (авлигын хэрэг)
	Гишүүн И У Хён баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2017.12.28)	Хэрэгсэхгүй болгосон	Тусгай эдийн засгийн гэмт хэргийн тухай хууль зөрчсөн (авлигын хэрэг)
	Гишүүн Хон Мүн Жун баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2018.4.4)	Буцаагдсан	Тусгай эдийн засгийн гэмт хэргийн тухай хууль зөрчсөн (авлигын хэрэг)
	Гишүүн Жом Дон Гын баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2018.4.13)	Буцаагдсан	Хуурамч данс ашиглалт, албан тушаалын зөрчил
	Гишүүн Канг Сон Гю баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2018.5.25)	Хэрэгсэхгүй болгосон	Албан тушаалын зөрчил, хууль бус сонгуулийн зардлын асуудал
21 дэх	Гишүүн Жон Жон Сон баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2020.10.5)	Батлагдсан	Сонгуулийн хууль зөрчсөн
	Гишүүн И Сан Жик баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2021.4.15)	Батлагдсан	Тусгай эдийн засгийн гэмт хэргийн тухай хууль (үнэт цаасны залилан)
	Гишүүн Жон Чан Мин баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2021.9.24)	Батлагдсан	Тусгай эдийн засгийн гэмт хэргийн тухай хууль (авлига)
	Гишүүн Но Ун Рэ баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2022.12.15)	Батлагдсан	Авлига, мөнгө угаах, сонгуулийн хууль зөрчсөн
	Гишүүн И Жэ Мён баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2023.2.21)	Буцаагдсан	Тусгай эдийн засгийн хууль (авлига), Үнэт цаасны хууль (залилан), Хуурамч гэрээ, Төрийн сангийн зүй бус зарцуулалт, Хуулийн этгээдийн удирдлагын хуулийн зөрчил
	Гишүүн Ха Ён Жэ баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2023.3.22)	Батлагдсан	Улс төрийн намын санхүүжилтийн хууль, Шилэн дансны хууль зөрчсөн
	Гишүүн Юн Гван Сок баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2023.5.26)	Батлагдсан	Сонгуулийн хууль зөрчсөн
	Гишүүн И Сан Ман баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2023.5.26)	Буцаагдсан	Сонгуулийн хууль зөрчсөн
	Гишүүн И Жэ Мён баривчлах зөвшөөрлийн тухай	Засгийн газар (2023.9.19)	Батлагдсан	Тусгай эдийн засгийн хууль (үнэт цаасны залилан, авлига), Сонгуулийн хууль, Эмнэлгийн үйлчилгээний хууль зөрчсөн

Эх сурвалж: Парламентын мэдээллийн эмхэтгэл (Анхдугаар Үндсэн хуульт Үндэсний Ассамблейгээс ~ 21 дүгээр Үндэсний Ассамблей хүртэл)"

Мөн БНСУ-ын Үндэсний Ассамблейн 1948-2024 оны хоорондох гишүүний баривчилгаа болон суллагдах хүсэлтийн статистикийг доорх хүснэгтээр (South Korea: National Assembly, 2025) харуулав.

Хүснэгт 6. БНСУ-ын Үндэсний Ассамблейн гишүүдийн баривчландсан болон суллах хүсэлтийн тоо, түүний шийдвэрлэгдсэн байдал (1948-2024)

Дугаар (Үндэсний Ассамблей)	**Баривчлагдсан гишүүдийн тоо**	**Суллах хүсэлтийн тоо**	**Шийдвэрийн үр дүн**	
			Баталсан	Буцаасан

(бүрэн эрх эхэлсэн он)				
Түр (Анхдугаар, 1948)	10	10	2	8
2 дахь (1950)	15	14	14	
3 дахь (1954)	2	4		4
4 дэх (1960)	4	1	1	
5 дахь (1963)	1			
6 дахь (1967)	3	3	2	
7 дахь (1967)	1	1		
8 дахь (1971)				
9 дэх (1973)	6			
10 дахь (1978)	1	3		2
11 дэх (1981)	1			
12 дахь (1985)	3	3		2
13 дахь (1988)	14			
14 дэх (1992)	11	4		4
15 дахь (1996)	8	1	1	
16 дахь (2000)	19	1	1	
17 дахь (2004)	3			
18 дахь (2008)	7			
19 дэх (2012)	6			
20 дахь (2016)	3			
21 дэх (2020)	4			
Нийт	**122**	**45**	**25**	**14**

Эх сурвалж: Парламентын мэдээллийн эмхэтгэл (Анхдугаар Үндсэн хуульт Үндэсний Ассамблейгээс ~ 21 дүгээр Үндэсний Ассамблей хүртэл)"

Дээрх үзүүлэлтээс харахад, нийт баривчлагдсан гишүүдийн 36.8%-д суллагдах хүсэлт тавьсан бөгөөд тал хувь батлагдсан байна. 1948–1960-аад оны үед (анхдугаар–4 дүгээр Ассамблей) баривчилгаа, суллах хүсэлт идэвхтэй байжээ. Энэ нь шинэ Үндсэн хуульт тогтолцооны улс төрийн тогтворгүй байдалтай холбоотой байна. 1970–1980-аад оны хувьд харьцангуй бага тохиолдол бүртгэгдсэн ч 12–16 дахь Ассамблейд ахин өсөлттэй болсон нь цэргийн дэглэм, ардчиллын шилжилтийн үеийн улс төрийн дарамтыг илэрхийлж байна. 2000 оноос хойш (16–21 дүгээр Ассамблей) гишүүдийн суллагдах хүсэлтүүдийн тоо харьцангуй бага, олонх нь батлагдаагүй байна. Энэ нь Үндэсний Ассамблейн гишүүдэд тавигдах хууль эрх зүйн зохицуулалт, парламентын хяналтын механизм хатуу болж буйг илэрхийлж байна.

Дээрхээс харахад, БНСУ-ын ардчилсан Үндсэн хуульт Үндэсний Ассамблей байгуулагдсанаас хойш 2023 оны байдлаар нийт 70 удаагийн баривчлах зөвшөөрлийн хүсэлтийг дээрх заалтын хүрээнд өргөн мэдүүлэгдсэнээс, 17 удаа (24%) нь батлагдсан, 20 удаа (29%) нь няцаагдсан байна. Үүнээс 4 удаа (6%) нь татгалзсан бөгөөд 29 удаа (41%) нь хэлэлцүүлэлгүйгээр дуусгавар болсон (үүнд 15 тохиолдол нь бүрэн эрхийн хугацаа дууссанаар хүчингүй болсон) байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. БНСУ-ын ардчилсан Үндсэн хуульт Үндэсний Ассамблей байгуулагдсанаас хойших гишүүний халдашгүй байдалд холбогдох статистик

Ангилал	Нийт (тоо)	Батлагдсан	Няцаагдсан	Татгалзсан	Хэлэлцээгүй (бүрэн эрх дуусгавар болсон)
Баривчлах зөвшөөрлийн санал	70	17	20	4	29 (15)
Суллах шаардлагын тогтоолын санал	45	25	14	2	4 (3)

Эх сурвалж: БНСУ-ын Үндэсний Ассамблей

Дээрхээс парламентын гишүүдийн баривчлах зөвшөөрөл болон суллах шаардлагын тогтоолын хүсэлтүүдийн тодорхой хэсэг нь няцаагдаж, эсхүл хугацаа дууссанаар

хэлэлцэлгүйгээр хүчингүй болж буй нь дархан эрхийн зохицуулалт парламентын гишүүдийг улс төрийн дарамт, хууль эрх зүйн зүй бусаар ашиглагдах эрсдэлээс хамгаалж, хууль тогтоох байгууллагын бие даасан байдал, тогтвортой үйл ажиллагааг хадгалах чухал үүрэгтэй хэрэгсэл болохыг харуулж байна.

1.3.2. Бүгд Найрамдах Эстони Улс (БНЭстУ)

БНЭстУ-ын хувьд парламентын гишүүний халдашгүй байдал (Inviolability), эрүүгийн болон иргэний хэргээс чөлөөлөгдөх, баривчлах зөвшөөрөлд холбогдох зохицуулалт нь Үндсэн хуулийн 62, 64 болон 76 дугаар зүйлд тусгагдсан. Үүнээс Үндэсний парламентын гишүүний халдашгүй байдлын хүрээ, агуулга нь сонгодог загварыг төлөөлдөг бөгөөд энэ нь: (1) парламентын гишүүний үг хэлэх эрх чөлөөг хамгаалах (хариуцлагаас ангид байх), (2) баривчлах, саатуулах, эрүүгийн хэрэг үүсгэхээс хамгаалах (дархлаа) гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ (European Parliament, 2014). Тухайлбал, Үндсэн хуулийн 62 дугаар зүйлд “Рийгикогугийн гишүүн өөрийн мандатаар хязгаарлагдахгүй бөгөөд Рийгикогийн нэгдсэн чуулган, эсхүл түүний аливаа байгууллагад өгсөн санал, илэрхийлсэн улс төрийн үзэл бодлынхоо төлөө хууль зүйн хариуцлага хүлээхгүй” гэж заасан бол 76 дугаар зүйлд “Рийгикогугийн гишүүн нь эрүүгийн хэргээр яллах ажиллагаанаас хамгаалагдсан байна. Гишүүний эсрэг эрүүгийн хэрэг зөвхөн Хууль зүйн канцлерын (Chancellor of Justice) санал болон Рийгикогугийн гишүүдийн олонхын зөвшөөрлөөр үүсгэж болно”[22] гэж хуульчилсан.

Харин гишүүний бүрэн эрх дуусгавар болох нөхцөлийг Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлд “Рийгикогугийн гишүүн Бүгд Найрамдах Улсын Засгийн газрын гишүүнээр томилогдсон тохиолдолд түүний мандатыг түдгэлзүүлж, Засгийн газрын гишүүний албан тушаалаас чөлөөлөгдсөн үед сэргээнэ”[23] хэмээн заасан. Дээрх нөхцөлөөр гишүүний мандат түдгэлзсэн, эсхүл хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд түүнийг хуульд заасан журмын дагуу орлох гишүүнээр сольж ажиллуулна. Орлогч гишүүн нь Рийгикогугийн гишүүний бүх эрхийг эдэлж, бүх үүргийг хүлээнэ.

Үндсэн хуулийн зохицуулалтаас гадна Рийгикогугийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлгээр гишүүний халдашгүй эрхэд холбогдох зохицуулалтыг тусгасан (European Parliament, 2014) байна.

Рийгикогугийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулиар гишүүний бүрэн эрх эхлэх, түдгэлзэх, дуусгавар болох үндэслэл, хугацаа, журмыг; орлогч гишүүн Рийгикогугийн гишүүнээр ажиллах, мөн түүний бүрэн эрх дуусгавар болох үндэслэл, журмыг; Рийгикогугийн гишүүний тангараг өргөх журам болон тангараг өргөх хэлбэр; Рийгикогугийн гишүүний эрх, үүргийг; Рийгикогугийн гишүүний албан тушаалтай үл нийцэх албан тушаал; Рийгикогугийн гишүүний үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдох баталгаа зэргийг зохицуулсан байна. Рийгикогугийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд Рийгикогугийн гишүүний мандат дуусгавар болох үндэслэлийг дараах байдлаар тогтоосон байна.[24] Үүнд:

(1) Рийгикогугийн гишүүний мандат нь дараагийн Рийгикогугийн сонгуулийн дүн зарлагдсан өдрөөс дуусгавар болно.

(2) Рийгикогугийн гишүүний мандат хугацаанаасаа өмнө дуусгавар болох үндэслэл нь:

1. төрийн өөр албан тушаал хашсан тохиолдолд;
2. түүнийг яллах тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон үед;

[22] БНЭстУ: Үндсэн хууль (The Constitution of the Republic of Estonia). (2015). https://www.riigiteataja.ee/en/eli/521052015001/consolide
[23] Мөн тэнд.
[24] БНЭстУ: Riigikogu гишүүдийн эрх зүйн байдлын тухай хууль (Status of Members of the Riigikogu Act). (2015). https://www.riigiteataja.ee/en/eli/516042015001/consolide

3. энэ хуульд заасан журмын дагуу өөрийн хүсэлтээр огцорсон тохиолдолд;
4. Дээд шүүх түүнийг урт хугацаанд үүргээ биелүүлэх боломжгүй гэж тогтоосон үед;
5. нас барсан тохиолдолд.

Энэхүү Рийгикогугийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн "Рийгикогугийн гишүүний мандат дуусгавар болох үндэслэл" нь Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн "Рийгикогугийн гишүүний мандат дараах тохиолдолд хугацаанаасаа өмнө дуусгавар болох" зохицуулалттай ижил байна.

Дээрх хоёр хуулийн зохицуулалтаас гол үндэслэл бүхий Рийгикогугийн гишүүний мандатыг албадан дуусгавар болгох үндсэн зохицуулалт нь Рийгикогугийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд:

> *"Рийгикогугийн гишүүний мандат дуусгавар болно: … 2) түүний эсрэг шүүхээс ял шийтгэх шийдвэр хүчин төгөлдөр болсон үед"* гэх зохицуулалт байна.

Үүний "эцсийн шийдвэр" гэсэн тодорхойлолт бүхий утга нь гишүүний халдашгүй байдлын эрхэд онцгой ач холбогдолтой. Энэ нь зөвхөн анхан шатны шийдвэр дээр бус, давж заалдах шатны шүүхийн бүх боломж дуусаж, шийдвэр хүчин төгөлдөр болсон үед мандат дуусгавар болно гэсэн баталгааг өгч улмаар парламентын гишүүний халдашгүй байдалтай холбоотой бусад гишүүд санал хураалт, хүсэлт өргөн барих зэрэг процедур байхгүй. Үүний үндсэн суурь зарчим нь гэм буруугийн презумпци бөгөөд Үндсэн хуулийн 22 дугаар зүйлд: *"Хэн нэгнийг эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүхийн ял шийтгэх шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл гэм буруутайд тооцож үл болно"* гэж заасантай холбоотой.[25]

Мөн Рийгикогугийн гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар бүлэг 18^5 дахь хэсэгт "Рийгикогугийн гишүүнд холбогдуулан процессын ажиллагаа явуулах буюу яллах дүгнэлт гаргах зөвшөөрөл авахын тулд Хууль зүйн канцлер, эсхүл Ерөнхий прокурор үндэслэл бүхий хүсэлт гаргана. Хүсэлтдээ уг зөвшөөрлийг авах зайлшгүй шаардлагатай гэдгийг хангалттай үндэслэлээр нотлон тайлбарласан байх ёстой" хэмээн заасан.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэг буюу "Яллах дүгнэлт бэлтгэх болон тодорхой процессын ажиллагаа явуулах тусгай журам" бүлэгт Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүд, Рийгикогугийн гишүүд, Ерөнхий аудитор, Хууль зүйн канцлер, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчдийн эсрэг яллах дүгнэлт бэлтгэх, мөн хуулийн 377 дугаар зүйлд заасан процессын ажиллагаа явуулахад холбогдох зохицуулалтыг тусгасан.[26]

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 376 дугаар зүйлд Яллах дүгнэлт бэлтгэх тусгай журмыг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

1. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүд, Рийгикогугийн гишүүд, Ерөнхий аудитор, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчдийн эсрэг яллах дүгнэлтийг зөвхөн Хууль зүйн канцлерын санал болон Рийгикогугийн гишүүдийн олонхын зөвшөөрлийн үндсэн дээр бэлтгэж болно.
2. Хууль зүйн канцлерын эсрэг яллах дүгнэлтийг зөвхөн Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн санал болон Рийгикогугийн гишүүдийн олонхын зөвшөөрлийн үндсэн дээр бэлтгэнэ.
3. Шүүгчийн эсрэг яллах дүгнэлтийг зөвхөн Дээд шүүхийн санал болон Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрлийн үндсэн дээр бэлтгэж болно.

---

[25] БНЭстУ:Үндсэн хууль (The Constitution of the Republic of Estonia). Хандах: https://www.riigiteataja.ee/en/eli/523042025002/consolide

[26] БНЭстУ: Эрүүгийн хэрэг хянан шалгах журам (Code of Criminal Procedure). (2003). Хандах: https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide

Дээрх зохицуулалтаас харахад, Рийгикогугийн гишүүний (орлогч гишүүн хамаарна) эсрэг яллах дүгнэлтийг бэлтгэх нь энгийн прокурорын бүрэн эрх биш, харин заавал Хууль зүйн канцлерын санал болон Рийгикогугийн гишүүдийн олонхын зөвшөөрлийн үндсэн дээр хийгдэх ёстой. Энэ зохицуулалт нь парламентын гишүүдийн улс төрийн халдашгүй байдлыг хамгаалах, улс төрийн зорилгоор эрүүгийн хэрэг үүсгэхээс сэргийлэхэд чиглэсэн (European Parliament, 2014).

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 377 дугаар зүйлд парламентын гишүүний саатуулахтай (баривчлах) холбоотой нэмэлт баталгааг тогтоосон.[27] Үүнд:

377 дугаар зүйл: Процессын тодорхой ажиллагаа явуулах тусгай журам

1. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүн, Рийгикогугийн гишүүн, Ерөнхий аудитор, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, эсхүл Дээд шүүхийн шүүгчийг сэжигтнээр саатуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эд хөрөнгө битүүмжлэх, биеийн үзлэг хийхийг Улсын Ерөнхий Прокурорын хүсэлтээр Хууль зүйн канцлерын зөвшөөрлийн үндсэн дээр хийж болно.
2. Шүүгч, эсхүл Хууль зүйн канцлерыг сэжигтнээр саатуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эд хөрөнгө битүүмжлэх, биеийн үзлэг хийхийг Улсын Ерөнхий Прокурорын хүсэлтээр Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрлийн үндсэн дээр хийж болно.
3. Энэ зүйлийн 1 ба 2 дахь хэсэгт заасан этгээдийг хэрэв үндсэн (нэгдүгээр зэргийн буюу....) гэмт хэрэг үйлдэж байхад нь газар дээр нь баривчилсан бол Хууль зүйн канцлерын, эсхүл Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр сэжигтнээр саатуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эд хөрөнгө битүүмжлэх, биеийн үзлэг хийх боломжтой.
4. Хэрэв энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан ажиллагаа Рийгикогугийн гишүүнд хамаарч хэрэгжсэн бол Улсын Ерөнхий Прокурор болон Рийгикогугийн даргад нэн даруй мэдэгдэнэ.
5. Шаардлагатай тохиолдолд Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, эсхүл Хууль зүйн канцлерын нь процессын ажиллагаа хийх зөвшөөрөл олгохын өмнө эрүүгийн хэргийн материалтай урьдчилан танилцаж болно.
6. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, эсхүл Хууль зүйн канцлер нь хүсэлт хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор тухайн процессын ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, эсхүл хүсэлтийг буцаах ёстой. Хэрэв хүсэлтийг буцаасан бол буцаах үндэслэлийг заавал бичгээр тайлбарлан мэдээлнэ.

Дээрхээс харахад, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 377 дугаар зүйлд зааснаар Рийгикогугийн гишүүнийг сэжигтнээр саатуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эд хөрөнгийг нь битүүмжлэх, биеийн үзлэг хийх зэрэг процессын ажиллагааг зөвхөн Улсын Ерөнхий прокурорын хүсэлт болон Хууль зүйн канцлерын зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэх боломжтой байна.[28] Хэрэв Рийгикогугийн гишүүн гэмт хэрэг үйлдэж байхдаа баригдсан бол Хууль зүйн канцлерын урьдчилсан зөвшөөрөл шаардагдахгүйгээр саатуулах ажиллагааг явуулж болно. Энэ тохиолдолд прокурорын байгууллага болон Рийгикогугийн даргад нэн даруй мэдэгдэж, парламентын институцийн (Рийгикогу) оролцоог хангах үүрэгтэй (European Parliament, 2014).

[27] БНЭстУ: Эрүүгийн хэрэг хянан шалгах журам (Code of Criminal Procedure). (2003). Хандах: https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide

[28] БНЭстУ: Хууль эрхийн нийтлэлийн сан (Riigiteataja): “Consolidated version of the Constitution of the Republic of Estonia”. Хандах: https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide

1.3.3. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

ХБНГУ-ын парламентын халдашгүй байдлын эрх зүйн зохицуулалт нь Үндсэн хуулийн (Grundgesetz) 46 дугаар зүйлд (2-4 дүгээр заалт) хуульчлагдсан. Уг зүйлээр дархан эрх (Indemnität (non-liability)) болон халдашгүй байдал (Inviolabilität (inviolability)) гэсэн хоёр агуулгыг хуульчилсан. Үүнээс Бундестагийн гишүүний халдашгүй байдалд холбогдох Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2-4 дэх хэсгийг харвал:

> (2) Гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэлээр Бундестагийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, эсхүл баривчлахыг хориглоно. Харин хэрэв гэмт хэрэг үйлдэж байх үед нь газар дээр нь, эсхүл дараагийн өдөр нь баривчилсан бол энэ хязгаарлалт үйлчлэхгүй.
>
> (3) Бундестагийн гишүүний хувийн эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээ авах, эсхүл Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд[29] заасны дагуу түүний эсрэг эрүүгийн хэрэг үүсгэхэд мөн адил Бундестагийн зөвшөөрөл шаардлагатай.
>
> (4) Гишүүний эсрэг эрүүгийн хэрэг үүсгэх болон Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд заасан ажиллагаа явагдаж байгаа тохиолдолд Бундестагийн шаардлагаар түүнийг саатуулсан, эсхүл биеийн эрх чөлөөг нь хязгаарласан арга хэмжээг нэн даруй зогсооно.[30]

Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийг хэрэгжүүлэх журам нь ***нэгдүгээрт,*** Холбооны Бундестагийн дотоод дэгийн тухай хууль (Geschäftsordnung des Deutschen Bundestages)-ийн 107 дугаар зүйл, ***хоёрдугаарт,*** Холбооны Бундестагийн дотоод дэгийн тухай хуулийн 6 дугаар хавсралтад тусгагдсан. Хавсралт 6 нь Бундестагийн гишүүдийн халдашгүй байдлыг түдгэлзүүлэх тухай шийдвэр ба дархлааны асуудлын зарчим (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль §50(3) ба Иргэний хэрэг хянан шийдвэрлэх хууль §382(3), Эрүүгийн хууль §90b(2), §194(4)-ийн дагуу)-ийг (цаашид 6 дугаар хавсралт гэх) тогтоосон.

Гуравдугаарт, Холбооны хэмжээнд мөрдөгдөх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдамж (Richtlinien für das Straf-und Bußgeldverfahren, RiStBV)-д Бундестаг болон Европын парламентын гишүүдийн эсрэг эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад хэрэглэх захиргааны журам болон дүрмийг тогтоосон. ***Дөрөвдүгээрт,*** “Парламентын гишүүдийн дархан эрхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх үндсэн зарчмууд” (Grundsätze in Immunitätsangelegenheiten)-д Бундестагийн гишүүдийн эрхийг түдгэлзүүлэх, эсхүл хадгалахтай холбоотой хүсэлтийг ямар байгууллага гаргах эрхтэйг тодорхойлох; эрүүгийн хэрэг, сахилгын хэрэг, эсхүл бусад хууль зүйн ажиллагаанд парламентын гишүүнийг татан оролцуулахад Бундестагийн зөвшөөрөл авах журмыг тогтоох; парламентын гишүүдийн эрх зүйн халдашгүй байдлыг хамгаалах ба улс төрийн зорилгоор хууль эрх зүйг ашиглан шахалт үзүүлэхээс сэргийлэх болон нөгөө талаас нь, хэрэв гишүүн жинхэнэ гэмт хэрэг үйлдсэн бол түүнд хууль зүйн хариуцлага тооцох боломжийг үл хаах (хязгаарлахгүй) зэрэг асуудлыг

[29] БНЭстУ-ын Үндсэн хуулийн 18 дугаар зүйл: “Хэн боловч үг хэлэх эрх чөлөө (Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), хэвлэлийн эрх чөлөө (Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), сургах, заах эрх чөлөө (Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг), цугларах эрх чөлөө (8 дугаар зүйл), нийгэмлэг байгуулах эрх чөлөө (9 дүгээр зүйл), захидал харилцаа, шуудан, харилцаа холбооны нууцлал (10 дугаар зүйл), өмчлөх эрх (14 дүгээр зүйл), эсхүл орогнол хайх эрх (16а дугаар зүйл)-ийг ардчилсан эрх зүйт үндсэн дэг журмыг устгах буюу эсэргүүцэх зорилгоор ашигласан тохиолдолд тухайн үндсэн эрхийг нь хасна. Үндсэн эрхийг хасах болон түүний цар хүрээг Холбооны Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэнэ.”

[30] ХБНГУ: Үндсэн хууль (Basic Law for the Federal Republic of Germany). (1949[2025]). Хандах: https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html

нарийвчлан тогтоосон байдаг (ялангуяа RiStBV-ийн 191–192b зүйл).[31] Эдгээр нарийвчилсан зохицуулалтуудыг харвал:

Нэгдүгээрт, Холбооны Бундестагийн дотоод дэгийн тухай хуулийн 107 дугаар зүйлд "Гишүүний дархан эрхтэй" холбоотой асуудлыг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

(1) Дархан эрхтэй холбоотой өргөдөл, хүсэлтийг Ерөнхийлөгч шууд Сонгуулийн хяналт, халдашгүй байдал болон дотоод дэгийн хороонд (Scrutiny of Elections, Immunity and the Rules of Procedure) шилжүүлнэ.

(2) Энэ хороо нь Бундестагийн гишүүдийн дархан эрхийг түдгэлзүүлэх тухай хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх талаар үндсэн зарчмуудыг (Хавсралт 6) тогтоож, тухайн тохиолдол бүрийн онцлогт нийцүүлэн Бундестагийн гаргах шийдвэрийн саналын төслийг боловсруулах ёстой.

(3) Шийдвэрийн саналын төслийг хэлэлцэх нь ямар нэг хугацааны хязгаарлалтгүй. Гэвч уг хэлэлцүүлэг хамгийн багадаа материалыг тараасnaас хойш гурав дахь өдрөөсөө эхлэх ёстой (§75, хэсэг 1, үсэг h). Хэрэв шийдвэрийн саналын төсөл тараагдаагүй бол түүнийг уншиж танилцуулна.

(4) Сонгуулийн хяналт, халдашгүй байдал болон дотоод дэгийн хяналтын хороо байгуулагдахаас өмнө, халдашгүй байдалтай холбоотой асуудлаар Бундестагт шууд шийдвэр гаргах тухай зөвлөмж танилцуулах эрхийг Ерөнхийлөгч эдэлнэ.[32]

Хоёрдугаарт, Бундестагийн дотоод дэгийн тухай хуулийн 6 дугаар хавсралтаар гишүүдийн халдашгүй байдлыг түдгэлзүүлэх, дархлаатай холбоотой асуудлын зарчмуудыг тогтоосон. Үүнд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (StPO) §50 (3), Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ZPO) §382 (3), Эрүүгийн хууль (StGB) §90b (2), §194 (4)-ийн дагуу шаардлагатай зөвшөөрлийг олгох журам багтсан. Энэ зохицуулалтын зорилго нь, нэг талаас, гишүүдийг улс төрийн зорилготой мөрдөн шалгалтаас хамгаалах, нөгөө талаас, тэднийг хууль зүйн хариуцлагаас ангид байлгах бус, харин хэрэгтэй тохиолдолд хуулийн хариуцлагад татах боломжийг хангах зорилготой. Энэхүү 6 дугаар хавсралтыг зохицуулалтыг ойлгомжтой тайлбарлах үүднээс доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 8. ХБНГУ-ын Бундестагийн гишүүний халдашгүй байдлыг түдгэлзүүлэхтэй холбоотой зарчмууд (Бундестагийн дотоод дэгийн тухай хууль, 6 дугаар хавсралт)

Зүйлийн гарчиг	**Зүйлийн агуулга**
А. Халдашгүй байдлын асуудлаарх зарчмууд	
1. Өргөдөл гаргах эрх бүхий этгээд	Гишүүний халдашгүй байдлыг түдгэлзүүлэх хүсэлт гаргах эрхтэй этгээдүүд нь: a) Улсын прокурор, шүүх, нэр төрд холбогдох хэргийг хэлэлцэх мэргэжлийн шүүхүүд, түүнчлэн хуульд заасны дагуу мэргэжлийн хяналт тавьдаг байгууллагууд; b) хувийн яллах хэрэг бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 383 дугаар зүйлд заасны дагуу шүүх хуралдаан эхлэхээс өмнөх шат; c) шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд, хэрэв шүүх өөрийн санаачилгаар хэрэгжүүлж чадахгүй тохиолдолд өр төлбөрийн этгээд (өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч/зээлдэгч); d) Сонгуулийн хяналт, халдашгүй байдал болон дотоод дэгийн хороо;
2. Бундестагийн Ерөнхийлөгчид мэдэгдэх ба хүсэлт гаргах журам	a) хэрэв Бундестаг сонгуулийн хугацаанд гишүүдийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэхийг зөвшөөрсөн бол, мөрдөн шалгах ажиллагаа эхлэхийн өмнө заавал Бундестагийн Ерөнхийлөгчид, боломжтой бол тухайн гишүүнд мэдэгдэнэ. Хэрэв гишүүнд мэдэгдээгүй бол шалтгааныг тайлбарлан Ерөнхийлөгчид мэдээлнэ. Харин Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 4-т заасан Бундестагийн хэрэг түр зогсоох эрх хүчин төгөлдөр хэвээр байна.

[31] ХБНГУ: Эрүүгийн хэрэг ба торгуулийн журам. RiStBV (Richtlinien für das Strafverfahren und das Bußgeldverfahren). (1977). Хандах: *http://www.verwaltungsvorschriften-iminternet.de/bsvwvbund_01011977_420821R5902002.htm*

[32] ХБНГУ: Bundestag-ийн Дотоод журам (Geschäftsordnung des Deutschen Bundestages). (1980[2024]). Хандах: *https://www.bundestag.de/parlament/aufgaben/rechtsgrundlagen/go_btg*

	b) Улсын прокурор, шүүхүүд хүсэлтээ Холбооны хууль зүйн сайдаар (Bundesminister der Justiz) дамжуулан Бундестагийн Ерөнхийлөгчид хүргүүлнэ. c) өр төлбөрийн этгээд (1(c)-д заасан) шууд Бундестагт хандаж болно.
3. Хэрэгт холбогдож буй Бундестагийн гишүүний байр суур	Гишүүний халдашгүй байдлын асуудал хэлэлцэгдэж байхад тухай гишүүн Бундестагт үг хэлэх эрхгүй бөгөөд “халдашгүй байдлыг цуцлах” тухай хүсэлт гаргасан ч Бундестаг үүнийг авч хэлэлцэхгүй. Гэхдээ намын бүлэг хүсвэл, тусгай хорооны (Сонгуулийн хяналт, халдашгүй байдал, дэгийн хороо) шийдвэрээр тухайн гишүүнд байр сууриа илэрхийлэх боломж олгож болно.
4. Шийдвэр гаргах журам	Халдашгүй байдлын эрхийн гол зорилго нь Бундестагийн ажил, үйл ажиллагаа хэвийн явагдахад чиглэнэ. Тухайн гишүүний халдашгүй байдлын талаар гаргах шийдвэр нь улс төрийн зорилгогүй, дур зоргоор биш, зөвхөн бодит үндэслэлтэй байх ёстой. Халдашгүй байдлыг цуцлах, эсхүл сэргээх шийдвэрийг Бундестаг өөрөө, бие даан гаргана. Энэ үед парламентын ашиг сонирхол, төрийн бусад байгууллагын эрх мэдэл, мөн тухайн гишүүний эрх ашиг зэргийг харгалзан үзнэ. Энэ шийдвэрийг гаргахдаа тухайн хэргийг нотлох баримтаар үнэлэхгүй, бас гишүүн буруутай, эсхүл буруугүй гэж тогтоохгүй.
5. Улс төрийн шинжтэй доромжлол эсэх	Улс төрийн шинжтэй доромжлол нь ердийн тохиолдолд гишүүний халдашгүй байдлыг цуцлах үндэслэл болохгүй. Улсын прокурор нь эрүүгийн хэрэг үүсгэх зөвшөөрөл авах хүсэлт гаргах эсэхээ шийдэхийн өмнө Бундестагийн тухайн гишүүнд буруутгагдаж буй асуудлын талаарх мэдээллийг хүргэж, түүнд байр сууриа илэрхийлэх боломж олгож болно. Улсын прокурорын гаргасан дүгнэлт (жишээлбэл, өргөдөл гаргасан хүний хувийн шинж чанар, эсхүл өргөдлийн ноцтой эсэхийг үнэлэх бусад нөхцөл) нь Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “хариуцлагад татах” гэсэн утгад хамаарахгүй. Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 1-д зааснаар, Бундестагийн гишүүн парламентын чуулганд, эсхүл түүний аливаа хороонд хэлсэн үг, өгсөн саналаасаа болж шүүх, захиргааны хариуцлагад татагдахгүй (гүтгэлгийн шинжтэй доромжлолыг эс тооцвол). Жишээ нь, парламент дотор хэлсэн энгийн доромжлолын улмаас эрүүгийн хариуцлага хүлээхгүй гэсэн үг. Тухайлбал: Парламент дотор гишүүний хэлсэн үг, санал өгсөн үйлдэлдээ эрүүгийн хариуцлага хүлээхгүй (зөвхөн гүтгэлэг байвал л хариуцлага хүлээнэ). Энэ зарчмаас үүдэж хэрэв гишүүн парламентын гадна улс төрийн сэдвээр хэн нэгнийг “доромжилсон” бол тэр нь энгийн доромжлол (жишээ нь, муухай үг хэлэх) бол халдашгүй байдлыг цуцлахгүй, өөрөөр хэлбэл хариуцлага тооцохгүй. Харин гүтгэлэг хийсэн бол халдашгүй байдлын хамгаалалт (хариуцлага хүлээлгэхгүй байх) үйлчлэхгүй. (Гишүүн гэдэг статусаараа биш, аливаа хэрэг маргаанд гэрчийн байр сууринаас доромжлол үйлдсэн бол парламентын доторх халдашгүй байдлын хамгаалалтад хамаарахгүй)
6. Гишүүнийг үйлдэл дээр нь баривчлах	Гишүүнийг үйлдэл дээр баривчилсан тохиолдолд, эсхүл дараагийн өдөр нь баривчилсан бол Бундестагийн зөвшөөрөл шаардлагагүй (Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2). Харин тухайн гишүүнийг сулласныхаа дараа дахин баривчлах, эсхүл дараагийн өдрөөс хойш баривчилбал энэ нь эрх чөлөөг хязгаарлаж буй үйлдэлд тооцогдох тул Бундестагийн зөвшөөрөл заавал хэрэгтэй.
7. Гишүүнийг баривчлах журам	a) сонгуулийн хугацаанд гишүүдийн эсрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон эрүүгийн хэрэг үүсгэхийг зөвшөөрсөн нь, өөрөө баривчлах (Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн, эсхүл 2) албадан авчрах зөвшөөрлийг хамруулахгүй. b) “баривчлах” (үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2) гэдэг нь зөвхөн урьдчилсан хорих арга хэмжээг хэлнэ. Харин ял шийтгэлийг биелүүлэх зорилгоор баривчлах бол дахин тусгай зөвшөөрөл шаардагдана. c) баривчлах зөвшөөрөл олгосон бол энэ нь мөн албадан авчрах зөвшөөрөлд хамаарна. d) харин эсрэгээрээ, албадан авчрах зөвшөөрөл нь баривчлах зөвшөөрлийг хамруулахгүй.
8. Эрх чөлөөг нь хязгаарлах болон албадан саатуулах (Vollstreckung von	Эрүүгийн хэрэг үүсгэхийг зөвшөөрсөн нь хорих ялыг шууд биелүүлэх зөвшөөрөл гэсэн үг биш. Хорих ял, эсхүл албадан саатуулахыг биелүүлэхийн тулд заавал Бундестагийн зөвшөөрөл хэрэгтэй. Ажиллагааг хялбаршуулах зорилгоор энэ зөвшөөрлийн талаар урьдчилсан шийдвэр гаргах эрхийг Сонгуулийн хяналт, халдашгүй байдал, дэгийн хороонд олгосон.

Freiheitsstrafen oder von Erzwingungshaft (§96, 97 OWiG))	Гэхдээ хорих ялд зөвхөн дараах нөхцөлд хороо урьдчилсан шийдвэр гаргаж болно: (1) ял нь 3 сараас дээшгүй хугацааны хорих ял байх; эсхүл (2) хэд хэдэн гэмт хэрэгт ялыг нийлүүлэн оноох үед нэг гэмт хэргийн ял нь 3 сараас ихгүй байх.
9. Сахилгын хэрэг	Хэрэв нэг гишүүний сахилгын зөрчлийг (жишээлбэл, албан тушаалын ёс зүйн болон сахилгын бууруутай үйлдэл) шийдвэрлэх зорилгоор түүний халдашгүй байдлыг цуцалсан тохиолдолд, уг зөвшөөрлийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх (яллагдагчаар татах, шүүхэд шилжүүлэх гэх мэт) зорилгоор ашиглах боломжгүй. Үүнтэй адил, гишүүний халдашгүй байдлыг эрүүгийн хэрэг явуулахын тулд цуцалсан байсан бол сахилгын хэрэг хянан шийдвэрлэх зөвшөөрөлд тооцогдохгүй. Харин сахилгын шийтгэлийг хэрэгжүүлэхдээ Бундестагаас дахин зөвшөөрөл авах шаардлагагүй.
10. Нэр төрийн болон мэргэжлийн шүүхийн хэрэг	Нийтийн эрх зүйн шинжтэй нэр төрийн болон мэргэжлийн шүүхийн ажиллагааг зөвхөн гишүүний халдашгүй байдлыг цуцалсны дараа явуулж болно.
11. Зам тээврийн хэрэг	Хэрэв гишүүн зам тээврийн зөрчил гаргавал, ердийн тохиолдолд түүнийг шалгах зөвшөөрлийг олгоно. Энэ асуудлыг хурдан шийдэхийн тулд бүх зам тээврийн хэрэг дээр урьдчилсан шийдвэрийг Сонгуулийн хяналт, халдашгүй байдал, дэгийн хороо гаргана.
12. Хөнгөн хэрэг (bagatellsachen)	Сонгуулийн хяналт, халдашгүй байдал, дэгийн хороо тухайн хүсэлтийг жижиг хэрэг гэж үзвэл, хороо өөрөө урьдчилсан шийдвэр (13 дугаар зүйлд заасны дагуу) гаргана.
13. Хялбаршуулсан журам	Сонгуулийн хяналт, халдашгүй байдал, дэгийн хороо энэ тогтоолын 8, 11, 12, В ба С-д заасны дагуу өөрт олгосон эрхийн хүрээнд урьдчилсан шийдвэр гаргасан бол Ерөнхийлөгч бичгээр Бундестагт мэдэгдэнэ. Мэдэгдсэнээс хойш долоо хоногийн дотор эсэргүүцэл гарахгүй бол энэ нь Бундестагийн шийдвэр гэж тооцно.
14. Тусгай тохиолдолд буу заавал зөвшөөрөл шаардлагатай ажиллагаа	Гишүүнийг баривчлахад Бундестагийн зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай тохиолдлууд: Үүнд: a) тодорхой үйлдлийг хийхээс татгалзах, эсхүл тэвчихийг албадсан тохиолдолд оногдуулсан захиргааны хорих ялыг биелүүлэхэд (ZPO §890, §901); *Хэрэв шүүхийн шийдвэр, эсхүл түр хугацааны хориг (einstweilige Verfügung) нь тодорхой үйлдлийг хийхээс татгалзах, эсхүл тэвчих үүргийг агуулсан бол, зөрчсөн тохиолдолд торгууль, эсхүл хорих ял оногдуулна гэж урьдчилан анхааруулдаг. Ийм анхааруулга нь тухайн үүргийг албадан биелүүлэх эрх зүйн норм тогтоосонтой адил гэж тооцогдоно. Иймээс тухайн норм буюу хүлээсэн үүргийг зөрчсөн эсэхийг шалгах нь Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн утгаар бол "ял шийтгэл оногдуулах хариуцлагад татах" үйлдэлд тооцогдоно. Учир нь энэ нь "ял шийтгэлээр заналхийлсэн үйлдэл"-ийг зөрчсөнтэй адил гэж үзнэ. Энэ үед тухайн ажиллагаа нь захиргааны хорих ял (Ordnungshaft), эсхүл торгууль (Ordnungsgeld) аль нь байхаас үл хамаарна.* b) гэрчийн мэдүүлгээс зайлсхийсэнтэй холбоотой хорих арга хэмжээ (StPO §70, ZPO §390), *Үүрэг хүлээгч тал (Schuldner)-ыг тангарагтай мэдүүлэг (eidesstattliche Versicherung) өгөхийг албадсан хэрэгт зөвхөн хорих шийдвэрийг хэрэгжүүлэх явдал нь Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн утгаар хувь хүний эрх чөлөөг хязгаарлаж буйд тооцогддог. Тиймээс ийм тохиолдолд л Бундестагаас зөвшөөрөл шаардагдана.* *Харин Сонгуулийн хяналт, халдашгүй байдал, дэгийн хороо нь дараах байр суурьтай байдаг: Бундестагийн гишүүнийг Үүрэг хүлээгч тал (Schuldner)-ын хувиар тангарагтай мэдүүлэг өгөхийг албадсан ажиллагаа, мөн шүүхээс ийм мэдүүлэг өгөхийг албадан хорих шийдвэр гаргасан тохиолдол нь шууд "хариуцлагад татах" гэж үзэгдэхгүй. Иймээс энэ тохиолдолд Бундестагаас зөвшөөрөл авах шаардлагагүй.* c) гэрч хуралдаанд ирээгүй тохиолдолд (банкрот) оногдуулдаг ажиллагааны хүрээнд хорих ял, эсхүл албадан авчрах ажиллагааг хэрэгжүүлэх (inso §21 abs. 3, §98 abs. 2),

	d) гэрч үндэслэлгүйгээр мэдүүлгээс татгалзсан тохиолдолд оногдуулсан захиргааны арга хэмжээ, эсхүл хорих ялыг хэрэгжүүлэх (StPO §70, ZPO §390) e) шүүхийн шийдвэрийн дагуу тухайн хүн өөрөө хийх ёстой, бусад хүн хийж орлуулж болохгүй үйлдлээ (жишээлбэл, гарын үсэг зурах, тодорхой мэдүүлэг өгөх гэх мэт) хийхээс зайлсхийвэл, түүнийг албадан биелүүлэх зорилгоор хорих арга хэмжээ (ZPO §888); f) хувь хүний аюулгүй байдлыг хангах зорилгоор оногдуулсан баривчилгаа, эсхүл эрх чөлөөг хязгаарлах бусад арга хэмжээг хэрэгжүүлэх (ZPO §933) буюу шүүхээс “аюулгүй байдлын баривчилгаа” (Sicherungsarrest) гэж нэрлэдэг хамгаалалтын арга хэмжээг авсан бол, түүнийг хэрэгжүүлэхдээ хорих эсхүл эрх чөлөөг хязгаарлах бусад хэлбэрийг ашиглахыг ойлгоно. g) шүүх хуралдааны үеэр зохисгүй авир гаргасны (Ungebühr) улмаас оногдуулсан захиргааны хорих ялыг хэрэгжүүлэх (GVG §178) буюу шүүх хурлын эмх журам алдагдуулах, хүндэтгэлгүй авир гаргавал оноодог хорих ялыг биелүүлэх тухай заалт. h) өрийн этгээд (Хариуцагч-Schuldner), эсхүл хамт өртэй этгээдийг албадан авчрах, мөн дампуурлын ажиллагаанд оноосон хорих ялыг хэрэгжүүлэх (InsO §21(3), §98(2)). i) Түр хугацаагаар эмнэлэг, эсхүл асрамжийн байгууллагад албадан байрлуулах (StPO §126a). j) Эрүүгийн хуулийн дагуу оноодог эрх чөлөөг хасах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх (StGB §61 ба түүнээс хойш) (жишээлбэл: албадан эмчилгээ, хамгаалах арга хэмжээ гэх мэт). k) албадан авчрах ажиллагаа явуулах (StPO §134, 230, 236, 329, 387). l) баривчлах шийдвэрийн дагуу гишүүнийг хорих (StPO §114, 125, 230, 236, 329).
16. Шалгагдаж буй хэрэг	Гишүүнээр сонгогдох үед нь аль хэдийнээ шалгагдаж байсан эрүүгийн хэрэг, мөн түүнд оноосон хорих арга хэмжээ, эрх чөлөөг хязгаарлах бусад шийдвэрүүд (14-р зүйлд дурдсан шиг) бүгдийг автоматаар түр зогсооно. Хэрэв тухайн хэргийг үргэлжлүүлэх гэж байгаа бол, хэрэв өмнө нь тухайн хэрэгт эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах зөвшөөрөл олгогдоогүй бол, заавал Бундестагаас шийдвэр гаргуулж зөвшөөрөл авах ёстой.[33]
17. Өршөөлтэй холбоотой хэрэг	Хэрвээ Бундестагийн гишүүний эсрэг хэрэг нь өмнө гарсан өршөөлийн улмаас шүүхийн шатанд үргэлжлэх боломжгүй бол, Сонгуулийн хяналт, халдашгүй байдал, дэгийн хороо дараах байдлаар шийдвэр гаргах эрхтэй: - Хороо ийм тохиолдолд “Бундестаг нь Өршөөлийн тухай хууль хэрэглэхэд эсэргүүцэхгүй” гэж мэдэгдэнэ. - Ингэснээр хэрэг албан ёсоор шүүхийн шатанд хэрэгсэхгүй болж дуусгавар болно. - Ийм тохиолдлыг Бундестагийн хуралд (plenary) дахин хэлэлцэх шаардлагагүй.

B. Эрүүгийн хэрэг үүсгэх зөвшөөрөл (StGB §90b (2), §194 (4)-ийн дагуу)

Гишүүн Бундестагийг доромжилсон (StGB §194 (4)), эсхүл Бундестагийг Үндсэн хуульд харш байдлаар гутаасан (StGB §90b (2)) бол түүнийг эрүүгийн хариуцлагад татахын тулд заавал Бундестагаас зөвшөөрөл авах ёстой.
Энэ зөвшөөрлийг урьдчилсан шийдвэрийн журмаар (13-р зүйлд заасан) олгож болно. Өөрөөр хэлбэл, Бундестаг бүхэлдээ хэлэлцэхийн оронд тусгай хороо урьдчилж шийдвэр гаргаж болно.
Прокурорууд ийм хэрэг үүсгэх хүсэлтээ шууд Бундестагт биш, харин Холбооны хууль зүйн сайдаар дамжуулан гаргана. Сайд уг хүсэлтийг Бундестагт уламжилж, “энэ хүнд хэрэг үүсгэх зөвшөөрөл олгох эсэх”-ийг шийдвэрлүүлнэ.

C. Гэрчээр мэдүүлэг авах зөвшөөрөл (StPO §50 (3), ZPO §382 (3)-ийн дагуу)

Хуульд зааснаар Бундестагийн гишүүнээс гэрчийн мэдүүлгийг парламентын байранд авах ёстой.
Харин өөр газар мэдүүлэг авах шаардлагатай бол тусгай хороо (Сонгуулийн хяналт, халдашгүй байдал, дэгийн хороо) урьдчилан зөвшөөрөл өгч болно.
Прокурор болон шүүх ийм хүсэлтээ шууд Бундестагийн Ерөнхийлөгчид гаргана.

[33] ХБНГУ: Bundestag-ийн Дотоод журам, Хавсралт 6 (Grundsätze in Immunitätsangelegenheiten), № 14. Хандах: https://www.bundestag.de/parlament/aufgaben/rechtsgrundlagen/go (Bei Übernahme des Abgeordnetenmandats anhängige Strafverfahren sowie jede angeordnete Haft, Vollstreckung einer Freiheitsstrafe oder sonstige Beschränkung der persönlichen Freiheit (vgl. Nummer 14) sind von Amts wegen auszusetzen)

Харин парламентын чуулган завсарласан үед гишүүнээс өөр газар мэдүүлэг авахад огт зөвшөөрөл шаардагдахгүй.

Гуравдугаарт, Холбооны хэмжээнд мөрдөгдөх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдамж (Richtlinien für das Straf-und Bußgeldverfahren, RiStBV)-ын 191 дүгээр зүйлд "Халдашгүй байдлын улмаас үүсэх процессын саад"-г, 192 дугаар зүйлд "Бундестаг болон мужийн хууль тогтоох байгууллагуудын гишүүдийн халдашгүй байдлыг түдгэлзүүлэх тухай" асуудлыг 192b дүгээр зүйлд Европын парламентын гишүүдэд холбогдох халдашгүй байдлын зохицуулалт байна. Энэхүү зохицуулалтаар Бундестагийн гишүүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх болон баривчлах ажиллагаанаас хамгаалагдах халдашгүй эрхтэй бөгөөд зөвхөн парламентын зөвшөөрлөөр ийм арга хэмжээ авах боломжтой.[34] Гэхдээ халдашгүй байдлыг туйлширсан байдлаар ойлгохгүй, тодорхой нөхцөлд прокурор болон мөрдөн шалгах байгууллагад шууд ажиллагаа явуулах боломжийг олгож хуульчилсан. Тухайлбал, гишүүн гэмт хэрэг үйлдэж байхдаа буюу дараагийн өдөрт нь баривчлагдсан бол парламентын зөвшөөрөл шаардагдахгүй. Мөн мөрдөн шалгах ажиллагаанд саад болохгүй байх үүднээс илт үндэслэлгүй өргөдлийг тайлбарлуулах, гэрчээр дуудан байцаах, ослын газарт шинжилгээ хийх, цусны шинжилгээ авах зэрэг ажиллагааг парламентын зөвшөөрөлгүйгээр хийж болно.[35] Ингэснээр ХБНГУ-ын тогтолцоо хоёр талын тэнцвэрийг баримталдаг гэж тооцогддог. Үүнд, нэг талаас парламентын бие даасан байдал, гишүүдийг улс төрийн дарамтаас хамгаалах зорилгоор дархан эрхийг баталгаажуулж, нөгөө талаас гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагааг үндэслэлгүйгээр саатуулж болохгүй гэсэн зарчмыг баримталж байна. Үүнээс үзэхэд, парламентын халдашгүй байдал нь "бүрэн хамгаалалт" бус харин хязгаарлагдсан дархан эрх хэлбэрээр хэрэгждэг бөгөөд зөвхөн хууль тогтоох байгууллагын үүргийг хамгаалахад чиглэсэн.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдамжийн 192 дугаар зүйлд "Парламентын гишүүний халдашгүй байдлыг түдгэлзүүлэх журам"-ыг зохицуулсан. Тус заалтаар прокурор парламентын гишүүнд эрүүгийн хэрэг үүсгэх, ял биелүүлэх, эсхүл өөр төрлийн эрүүгийн хариуцлагын арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл тухайн гишүүн харьяалагдаж буй хууль тогтоох байгууллагаас заавал зөвшөөрөл гаргуулах ёстой гэж тогтоосон.[36] Үүнд хамаарах өргөдөл нь баримт бүхий танилцуулга болон эрх зүйн тайлбартай байх ёстой бөгөөд гүйцэтгэх гэж буй үйлдлийн хууль зүйн шинж, үйлдсэн цаг хугацаа, газар, зөрчигдсөн байж болох хуулийн зүйл заалт зэргийг тодорхой тусгах шаардлагатай.[37] Ял шийтгэл биелүүлэх зөвшөөрөл хүсэж буй тохиолдолд холбогдох шүүхийн шийдвэрийг баримт бичиг хавсаргана. Хэрэв прокурор парламентын гишүүнд эрүүгийн хэрэг үүсгэх, эсхүл ял оногдуулах хүсэлт гаргавал эхлээд тухайн гишүүн харьяалагдаж байгаа парламент (Бундестаг, эсхүл мужийн хууль тогтоох байгууллага)-аас зөвшөөрөл авах ёстой. Ийм зөвшөөрөл авах хүсэлтийг прокурор Бундестагийн Ерөнхийлөгчид гаргана. Хэрэв уг хүсэлт нь Бундестагийн гишүүнд хамааралтай бол энэ өргөдлийг заавал Холбооны шүүхийн асуудал эрхэлсэн яамаар дамжуулж хүргэнэ. Өргөдлийн хуулбарыг мөн тухайн мужийн шүүхийн удирдлага болон холбооны түвшинд холбогдох яаманд илгээх процесс явагдана.[38] Мөн ХБНГУ-ын эрүүгийн эрх зүй дэх Privatklage буюу хувийн гомдлын хэрэг гэж тусгай ангилал байна. Энэ нь ихэвчлэн хөнгөн гэмт хэргийн шинжтэй үйлдэл (жишээлбэл: доромжлол, нэр төр гутаах, биеийн хөнгөн гэмтэл гэх мэт) бөгөөд хохирогч өөрөө шууд шүүхэд нэхэмжлэл гаргаж хэрэг үүсгэдэг онцлогтой байна. Өөрөөр хэлбэл, төрийн (прокурорын) санаачилгаар бус, харин

[34] ХБНГУ: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдамж (Richtlinien für das Straf-und Bußgeldverfahren, RiStBV). §191. Хандах: *https://www.gesetze-bayern.de/Content/Document/RiStBV-G1*
[35] Мөн тэнд. §191.
[36] Мөн тэнд. §192.
[37] ХБНГУ: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдамж (Richtlinien für das Straf-und Bußgeldverfahren, RiStBV). §192 Abs.2. Хандах: https://www.gesetze-bayern.de/Content/Document/RiStBV-G1
[38] Мөн тэнд. §192 Abs.3.

хувь хүний санаачилгаар явагддаг хэрэг гэж хэлж болно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдамжийн 192 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу хэрэв парламентын гишүүн ийм төрлийн хувийн гомдлын хэрэгт холбогдсон тохиолдолд, прокурор шууд гишүүний халдашгүй байдлыг түдгэлзүүлэх хүсэлт гаргаж болохгүй.[39] Зөвхөн тухайн хэргийг прокурор төрийн өмнөөс үргэлжлүүлэн хянан шалгах гэж шийдсэн нөхцөлд л прокурор парламентын зөвшөөрөл авах шаардлагатай нөхцөл үүсдэг байна. Энэ зохицуулалтыг Вернер Майер-Гёсснер (Werner Meyer-Goßner) Бернхард Шмитт (Bernd Schmitt) нарын судлаачид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль: StPO, GVG, EGGVG болон бусад хууль тогтоомжийн тайлбар (Strafprozessordnung: StPO mit GVG, EGGVG und Nebengesetze) бүтээлдээ (Meyer-Goßner & Schmitt, 2023); мөн Жөрн Ипсен (Jörn Ipsen)-ийн "ХБНГУ-ын парламентын халдашгүй байдал" (Parlamentarische Immunität in Deutschland) хэмээх бүтээлд (Ipsen, 2010) дараах хоёр санаагаар тайлбарласан. Үүнд:

1. Парламентын гишүүнийг хөнгөн, хувийн шинжтэй маргаанд хууль ёсны шалтгаангүйгээр халдашгүй байдлыг нь хязгаарлахгүй байх баталгаа нь энэ заалт байна. Учир нь ийм хэргийг хүн бүр гаргах боломжтой тул улс төрийн зорилгоор гишүүдийг дарамтлах эрсдэлийг үүсгэнэ.
2. Улс төрийн шалтгаанаар зохиомол гомдол гаргах эрсдэлээс хамгаалах үүднээс Парламентын зөвшөөрөл авах механизмыг зөвхөн прокурор хэргийг төрийн хэрэг (улсын хэмжээний, нийтийг хамарсан) гэж үзэн үргэлжлүүлэх тохиолдолд ашиглана. Ингэснээр хувийн гомдол нэрийн дор гишүүдийг улс төрийн дарамтад оруулах боломжийг хязгаарлана.

Дөрөвдүгээрт, ХБНГУ-ын Үндсэн хууль (Grundgesetz) болон Бундестагийн дотоод журамд суурилсан "Парламентын гишүүдийн дархан эрхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх үндсэн зарчмууд" (Grundsätze in Immunitätsangelegenheiten) нь парламентын гишүүдийн халдашгүй байдлыг зохицуулах нарийн журмыг тогтоодог. Энэ нь гишүүний халдашгүй байдлыг зөвхөн хувь гишүүний ашиг сонирхлоор бус, харин парламентын нийтлэг үйл ажиллагааны бие даасан байдал, тасралтгүй байдлыг хамгаалах зорилготой гэж үздэг. Парламентын гишүүдийн дархан эрхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх үндсэн зарчмууд (Grundsätze in Immunitätsangelegenheiten)-д[40] Бундестагийн гишүүдийн эрхийг түдгэлзүүлэх буюу үндсэн зарчмуудыг тусгасан. Гишүүдийн эрхийг түдгэлзүүлэх ерөнхий зарчим нь Бундестагийн гишүүдэд эрүүгийн болон захиргааны хэрэг үүсгэх, баривчлах, ял шийтгэл гүйцэтгэх зэрэг арга хэмжээг зөвхөн Бундестагийн зөвшөөрлөөр хийнэ. Халдашгүй байдлыг түдгэлзүүлэх хүсэлтийг гаргах эрх (Antragsberechtigung) нь зөвхөн тодорхой байгууллагуудад байдаг.[41] Үүнд:

- Улсын прокурор, шүүх, мэргэжлийн болон ёс зүйн хяналтын байгууллагууд;
- Хувийн гомдлын хэрэгт (§383 StPO) шүүх;
- Гүйцэтгэл хангуулах шатанд орсон өр, төлбөрийн хэрэгт холбогдсон зээлдүүлэгч;
- Бундестагийн Сонгуулийн хяналт, халдашгүй байдал болон дотоод дэгийн хяналтын хороо тус тус байна.

Дээрх байгууллагуудаар хүсэлт гаргах хүрээг хязгаарласнаар гишүүний халдашгүй байдлын асуудлыг улс төрийн ашиг сонирхлоор бус, хууль ёсны хүрээнд шийдвэрлэх баталгаа үүсдэг. Ерөнхий зөвшөөрлийн журам (Generalklausel)-ын хүрээнд Бундестаг урьдчилан тогтоосон нөхцөлд зарим төрлийн ажиллагаанд (жишээлбэл, замын хөдөлгөөний жижиг

[39] Мөн тэнд. §192 Abs.4.
[40] ХБНГУ: Парламентын гишүүдийн дархан эрхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх үндсэн зарчмууд. Хандах: https://www.gesetze-im-internet.de/btgo1980anl_6/BJNR012610980.html
[41] ХБНГУ: Парламентын гишүүдийн дархан эрхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх үндсэн зарчмууд. Хандах: https://www.gesetze-im-internet.de/btgo1980anl_6/BJNR012610980.html

зөрчил, торгуулийн хэрэг (bagatellsachen) гэх мэт) дархан эрхийн хамгаалалтыг автоматаар түдгэлзүүлж хуулийн дагуу хариуцлагаа авах бөгөөд энэ зохицуулалт парламентын хэт ачааллыг бууруулах зорилготой. Ерөнхий прокурор, эсхүл шүүхийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг Бундестагийн Халдашгүй байдлын хороо авч хэлэлцэн, санал дүгнэлт гаргадаг. Шалгалт явуулахдаа гишүүний нэр хүнд, парламентын үйл ажиллагааны бие даасан байдлыг хамгаалах зорилгоор мэдээллийг нууцлалтай авч үздэг.[42]

1.3.4. Япон Улс

Япон Улсын парламентын гишүүний халдашгүй байдлын эрх зүйн зохицуулалт нь Үндсэн хуулийн 50, 51 дүгээр зүйлд тусгагдсан байдаг. Үндсэн хуулийн 51 дүгээр зүйл нь хариуцлагаас чөлөөлөх (non-accountability) зарчмыг тогтоодог бол 50 дугаар зүйл нь халдашгүй байдлыг (inviolability) зохицуулдаг. Үндсэн хуульд ийм байдлаар хоёр эрхийг тусад нь зохицуулсан нь эдгээр хамгаалалтын шинж чанар тус бүрийн ялгаатай байдалтай холбоотой. Парламентын гишүүний халдашгүй байдлын зохицуулалт нь онцгой бөгөөд тодорхой хугацааны хязгаарлалттай байна. Үндсэн хуулийн 50 дугаар зүйлд зааснаар, “Хуульд өөрөөр заасан тохиолдлоос бусад үед, Төлөөлөгчдийн танхим болон Зөвлөхүүдийн танхимын гишүүд нь Парламент хуралдаж байгаа хугацаанд баривчлагдахаас чөлөөлөгдөнө. Чуулган эхлэхээс өмнө баривчлагдсан гишүүнийг тухайн танхимын шаардсанаар чуулганы хугацаанд суллана”[43] гэж заасан. Энэ нөхцөл нь Японы загварын төв шинж бөгөөд халдашгүй байдлыг хууль тогтоох байгууллагын идэвхтэй үйл ажиллагаатай шууд холбож өгсөн хэмээн тайлбарлагддаг. Өөрөөр хэлбэл, энэ хамгаалалтын зорилго нь гишүүний нэр төр, байр суурийг байнга хамгаалахад бус, харин тухайн цаг үеийн чуулганы ажлыг саатуулах, саад учруулах эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн. Үндсэн хуулийн зохицуулалтаас гадна, парламентын гишүүдийн халдашгүй байдлыг нарийвчлан зохицуулсан хууль тогтоомж болон холбогдох баримт бичгүүд ч мөн хүчин төгөлдөр үйлчилж байна.Үүнд:

1. Японы Үндсэн хууль (*Constitution of Japan*)[44]
2. Үндэсний парламентын тухай хууль (*National Diet Law*)[45]
3. Үндэсний парламентын хуралдааны дүрэм (*Rules of the National Diet*)[46]
4. Зөвлөхүүдийн танхимын дүрэм (*Rules of the House of Councillors*)[47]
5. Төлөөлөгчдийн танхимын дүрэм (*Rules of the House of Representatives*)[48]
6. Танхимуудын хамтарсан журам (*Rules of Procedure of Both Houses* (зарим эх сурвалжид *Joint Rules of Both Houses*))[49]
7. Танхимын дотоод дэгийн журам (*House Internal Regulations* (эсхүл, *Standing Orders of the House*)[50]

[42] ХБНГУ: Парламентын гишүүдийн дархан эрхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх үндсэн зарчмууд. Хандах: https://www.gesetze-im-internet.de/btgo1980anl_6/BJNR012610980.html
[43] Япон Улс: Үндсэн хууль (1946[1947]). Хандах: https://www.sangiin.go.jp/japanese/aramashi/houki/01kenpou/index.html
[44] Мөн тэнд.
[45] Япон Улс: Үндэсний парламентын тухай хууль (National Diet Law). (1947). Хандах: https://www.sangiin.go.jp/eng/law/diet/index.htm
[46] Япон Улс: Үндэсний парламентын хуралдааны дүрэм (Rules of the National Diet). Хандах: https://www.sangiin.go.jp/japanese/aramashi/houki/03kokkaikaigi/index.html
[47] Япон Улс: Зөвлөхүүдийн танхимын дүрэм (Rules of the House of Councillors). Хандах: https://www.sangiin.go.jp/japanese/aramashi/houki/03saninkisoku/kisoku.html
[48] Япон Улс: Төлөөлөгчдийн танхимын дүрэм (Rules of the House of Representatives). Хандах: https://www.shugiin.go.jp/internet/index.nsf/html/index_e.htm
[49] Япон Улс: Танхимуудын хамтарсан журам (Rules of Procedure of Both Houses).
[50] Япон Улс: Танхимын дотоод дэгийн журам (Standing Orders of the House).

Дээрхээс Парламентын тухай хууль (Diet Law)-ын дараах бүлгүүдэд гишүүний халдашгүй байдалд холбогдох зохицуулалтууд байна.[51]

Хүснэгт 9. Япон Улсын Үндэсний парламентын тухай хуульд гишүүний халдашгүй байдлыг зохицуулсан нь

№	Хуулийн бүлэг, нэр	Зүйлийн агуулга
1	4 дүгээр бүлэг: Парламентын танхимуудын гишүүд (Members of the Houses of the Diet)	Энэ бүлэгт гишүүдийн эрх, үүрэг, халдашгүй байдал, баривчлах болон эрүүгийн хэрэг үүсгэхэд холбогдох журмуудыг тусгасан. Энэ зохицуулалт нь Үндсэн хуульд (50, 51 дүгээр зүйл) заасан халдашгүй байдлыг хэрэгжүүлэхэд холбогдох дэлгэрэнгүй журамд тооцогддог.
2	13 дугаар бүлэг: Огцрох, тэтгэвэрт гарах, хоосон суудлыг нөхөх ба гишүүний бүрэн эрхэд холбогдуулан маргаан гаргах (Resignation, Retirement, Filling of Vacancies and Challenge to Member's Qualification)	Хэрвээ гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдвол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх үндэслэл болох бөгөөд хуулийн 13 дугаар бүлэгт заасан журмаар тухайн гишүүнийг бүрэн эрхээс нь чөлөөлөх асуудал яригдана.

Нэгдүгээрт, Парламентын тухай хууль (Diet Law)-ийн 4 дүгээр бүлгийн 33 дугаар зүйлд заасны дагуу “Чуулган хуралдаж байх хугацаанд, тухайн гишүүнийг танхимын зөвшөөрөлгүйгээр баривчлахгүй. Гэхдээ танхимын гадна гэмт хэрэг үйлдэж байгаад үйлдэл дээрээ баригдсан тохиолдолд энэ үл хамаарна”.[52] Мөн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гишүүнийг баривчлахад танхимын зөвшөөрөл шаардлагатай тохиолдолд, эрх бүхий шүүх, эсхүл шүүгч баривчлах зөвшөөрөл олгохоос өмнө, Засгийн газар тухайн бичгээр ирүүлсэн хүсэлтийн хуулбарыг хавсарган танхимд өргөн мэдүүлэх үүрэгтэй” бөгөөд 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу “Гишүүн чуулган эхлэхээс өмнө баривчлагдсан бол, Засгийн газар тухайн гишүүний нэр болон баривчлах зөвшөөрлийн хуулбарыг чуулганы нээлтийн үеэр танхимын даргад мэдэгдэх ёстой”. Хэрвээ шүүгч чуулганы үеэр чуулган эхлэхээс өмнө баривчлагдсан гишүүний саатуулах хугацааг сунгах шийдвэр гаргавал Засгийн газар энэ тухайг мөн танхимын даргад мэдэгдэх ёстой” байна. Түүнчлэн “Чуулган эхлэхээс өмнө баривчлагдсан гишүүнийг суллуулах хүсэлт гаргахын тулд тайлбар бүхий бичгэн хүсэлтийг 20 буюу түүнээс дээш гишүүд хамтран гарын үсэгтэйгээр танхимын даргад өргөн мэдүүлнэ” зохицуулалтыг хуулийн 34 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан байна.

Энэхүү Парламентын тухай хуулийн 33–34-III дугаар зүйл нь парламентын гишүүдийг улс төрийн зорилгоор, үндэслэлгүйгээр баривчлах, эрүүгийн хэрэг үүсгэхээс хамгаалах зорилготой бөгөөд гишүүнийг баривчлахад танхимын зөвшөөрөл шаардах, чуулган эхлэхээс өмнө баривчлагдсан бол танхимд мэдээлэх, мөн суллагдах хүсэлтийг тодорхой тооны гишүүд хамтран гарын үсгээр хүсэлт өргөн мэдүүлэх зэрэг процессоор дамжуулан парламентын бие даасан байдал, гишүүний халдашгүй байдлыг баталгаажуулах зохицуулалт байна.

Хоёрдугаарт, Парламентын тухай хууль (Diet Law)-ийн 13 дугаар бүлэг буюу гишүүн огцрох, тэтгэвэрт гарах, хоосон суудлыг нөхөх ба гишүүний бүрэн эрхэд холбогдуулан 111 дүгээр зүйлд “Гишүүний бүрэн эрхэд маргаан гарсан тохиолдолд тухайн асуудлыг эрх бүхий хороо (Дэг ба захиргааны хороо (Committee on Rules and Administration)) хэлэлцсэний дараа танхим шийдвэр гаргана. Ийм маргааныг танхимын гишүүний нэрээр хаяглан бичгээр танхимын даргад өргөн мэдүүлэх ёстой” гэж заасан. Хуулийн 12 дугаар зүйлд “Бүрэн эрхэд нь маргаан гаргасан гишүүн өөрийн эрх ашгийг хамгаалуулахын тулд хамгийн ихдээ хоёр өмгөөлөгч томилж болно. Дээрх хоёр өмгөөлөгчийн нэгийн зардлыг төр хариуцна” гэж заасан. Хуулийн 113 дугаар зүйлд “Гишүүн бүрэн эрхээсээ түдгэлзэх ёстой нь нотлогдох хүртэл

[51] Япон Улс: Үндэсний парламентын тухай хууль (National Diet Law). (1947). Хандах: https://www.sangiin.go.jp/eng/law/diet/index.htm
[52] Мөн тэнд.

гишүүний бүрэн эрхээ хадгална. Гэвч өөрийн бүрэн эрхийн тухай маргааныг хэлэлцэж буй хуралдаанд санал өгөх эрхгүй бөгөөд зөвхөн өөрийгөө өмгөөлөх боломжтой”[53] хэмээн тус тус заасан байна.

Үндсэн хууль болон Үндэсний парламентын тухай хууль (Diet Law)-аас гадна Танхимын дотоод дэгийн журам (議院規則)-аар гишүүний халдашгүй байдалд холбогдох зохицуулалтыг хийсэн байна. Тухайлбал, Япон Улсын хууль тогтоох байгууллагатай холбоотой зохицуулалт нь Үндсэн хууль, Үндэсний парламентын тухай хууль, түүнчлэн танхим тус бүрийн тогтоосон журам, дэг, дүрмээс бүрдэнэ.[54] Танхимын дотоод дэгийн журам нь танхимын тогтоолоор батлагддаг бөгөөд “хуралдааны болон бусад ажиллагаа, дотоод зохион байгуулалттай холбоотой журам” юм (Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсэг). Энэ нь Үндсэн хууль болон Үндэсний парламентын тухай хуулиас доогуур эрх зүйн хүчин чадалтай бөгөөд тодруулбал, Төлөөлөгчдийн танхимын журам, Зөвлөхүүдийн танхимын журам, мөн хоёр танхимын хамтарсан хурлын журам, байнгын хороодын хамтарсан хуралдааны журам зэрэг багтана. Танхимын дотоод дэгийн журам нь ердийн хууль тогтоомжтой харьцуулахад хүлээн зөвшөөрөгдөх хүрээ нь хязгаарлагдмал. Ийм төрлийн журам нь тухайн танхимын гишүүн, төрийн сайд, журмаар зохицуулсан харилцаанд шууд оролцож буй этгээдүүдэд үйлчлэх бөгөөд танхимын гадна ажиллаж буй төрийн албан хаагч, эсхүл иргэдэд үйлчлэхгүй буюу хамаарахгүй. Танхимын дотоод дэгийн журам нь “Олон нийтэд зориулсан албан ёсны мэдээ”-нд нийтлэгддэггүй, харин “Үндэсний парламентын тайлан”-д нийтлэгддэг.

[53] Япон Улс: Үндэсний парламентын тухай хууль (National Diet Law). (1947). Хандах: https://www.sangiin.go.jp/eng/law/diet/index.htm
[54] Япон Улс: Үндэсний парламентын дүрэм (Rules of the Diet). (n.d.). Хандах: https://ndlsearch.ndl.go.jp/rnavi/politics/post_1197

ХОЁР. ГИШҮҮНИЙ ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Хариуцлагаас чөлөөлөгдөх (non-accountability)-д холбогдох олон улсын эрх зүйн зохицуулалт

Парламентын халдашгүй байдлын хоёр дахь хэсэгт хамаарах парламент дахь үг хэлэх, санал өгөхтэй холбоотой хамгаалалт (non-accountability) нь гишүүдийг үүргээ гүйцэтгэх явцдаа өгсөн санал, илэрхийлсэн үзэл бодлынх нь төлөө эрүүгийн болон бусад хариуцлага хүлээлгэхээс хамгаалах зохицуулалт хамаарна. Парламентын халдашгүй байдал түүний дотор хариуцлагаас чөлөөлөгдөх зохицуулалтад холбогдох дараах баримт бичгүүд байна. Үүнд:

Хүснэгт 10. Парламентын халдашгүй байдлын хүрээнд хариуцлагаас чөлөөлөгдөхөд хамаарах олон улсын эрх зүйн зохицуулалт

Хамаарах зохицуулалт агуулсан баримт бичиг	**Хамаарах халдашгүй байдал**	**Тайлбар**
ЕХ-ны дархан эрх, халдашгүй байдлын тухай протокол (1965) (Protocol on the Privileges and Immunities of the EU (1965))	Хариуцлагаас чөлөөлөгдөх (non-accountability)	Европын Парламентын гишүүд Парламентын үйл ажиллагаанд өгсөн санал, хэлсэн үгийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй.
Европын Зөвлөлийн Парламентын Ассамблейн дүрэм (Rules of Procedure of the Parliamentary Assembly of the Council of Europe (PACE))		Ассамблейн гишүүд хуралдаан, санал хураалтын үеэр хэлсэн үгнийхээ төлөө хариуцлага хүлээхгүй.
Европын хүний эрхийн конвенц (1950) (European Convention on Human Rights (1950))		Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх. Парламентын хэлэлцүүлэгт шууд хэрэглэгдэнэ.

Эх сурвалж: Судлаачийн ангилан боловсруулснаар.

Парламент дахь үг хэлэх, санал өгөхтэй холбоотой хамгаалалт (non-accountability)-ын талаар олон улсын хэмжээний зохицуулалтыг харвал:

Нэгдүгээрт, "Европын Парламент болон Европын Холбооны гишүүн орнуудад парламентын халдашгүй байдлын дүрэм" -д холбогдох зохицуулалт байна. Үүнд, тухайлбал, Европын Холбооны Дархан эрх, халдашгүй байдлын тухай протокол (PPI) нь ЕХ-ны анхдагч эрх зүйн эх сурвалжийн статустай бөгөөд гишүүн орнуудын нутаг дэвсгэр дээр парламентын гишүүн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай дархан эрх, халдашгүй байдлын талаарх эдлэх эрх, нөхцөлийг тогтоож өгдөг. Дархан эрх, халдашгүй байдлын тухай протокол нь Европын Холбооны парламентын гишүүдийн хариуцлагаас ангид байх зохицуулалтыг дараах байдлаар тогтоосон байдаг. Үүнд: Протоколын 8 болон 9 дүгээр зүйлд санал, үзэл бодлын тухай абсолют дархан эрхийг тусгасан (European Central Bank (ECB), 2003). Тухайлбал, протоколын 3 дугаар бүлэг, 8 дугаар зүйлд “Европын Парламентын гишүүд хурлын байранд ирэх, буцах үед тэдний чөлөөтэй зорчих эрхэд аливаа захиргааны болон бусад хязгаарлалт тогтоохгүй. Европын Парламентын гишүүдэд гааль, валютын хяналтын хүрээнд: a) өөрийн улсын Засгийн газраас түр хугацааны албан томилолтоор гадаадад явж буй дээд албан тушаалтанд олгодогтой адил нөхцөл, боломжийг; b) Бусад гишүүн улсын Засгийн газраас түр хугацааны албан томилолтод явж буй гадаад улсын Засгийн газрын төлөөлөгчдөд олгодогтой адил нөхцөл, боломжийг олгоно” гэж заасан бол 9 дүгээр зүйлд “Европын Парламентын гишүүд үүргээ биелүүлэх явцдаа илэрхийлсэн үзэл бодол, өгсөн саналаараа ямар нэгэн мөрдөн шалгах ажиллагаа, баривчилгаа, эсхүл хууль зүйн хариуцлагад хамрагдахгүй” (European Central Bank (ECB), 2003) хэмээсэн. Дээрх заалтын хамрах хүрээ нь Европын

парламентын гишүүд албан үүргээ хэрэгжүүлэх явцад илэрхийлсэн үзэл бодол, өгсөн саналтай холбоотойгоор мөрдөн шалгах, баривчлах, эсхүл шүүхийн ажиллагаанд татагдахгүй. Энэ нь гишүүдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хараат бус байдалд нь баталгаа болж, улс төрийн хэлэлцүүлгийн дархлааг болон төлөөллийн ардчиллын хэвийн ажиллагааг хамгаалдаг. Энэ нь зарим үндэсний зохицуулалтаас ялгаатай нь гүтгэн доромжилсон шинжтэй үзэл бодолд ч үйлчилдэг. Харин энэ хамгаалалт нь намын дотоод хурлын үеийн, сонгуулийн сурталчилгаа, эсхүл нийтлэл, номд өгүүлсэн үзэл бодолд ерөнхийдөө хамаардаггүй. Үүнийг Европын Холбооны Шүүх (CJEU)-ээс энэхүү абсолют дархан эрх нь Европын парламентын хүрээнд хийгдсэн мэдэгдэлд хамаарна" (European Central Bank (ECB), 2003) хэмээн тайлбарласан. Гэвч иргэдийн нийтлэг ашиг сонирхолтой шууд, тодорхой утгаар холбоотой зүйл байгаа бол парламентын гадна илэрхийлэгдсэн байсан ч хамрагдаж болно. Харин үзэл бодол, илэрхийлсэн санаа нь энэ дархан эрхийн хүрээнд хамаарах эсэхийг эцэслэн шийдэх эрх нь парламент бус, үндэсний шүүхүүдэд байдаг. Парламент дахь үг хэлэх, санал өгөхтэй холбоотой хамгаалалтын хамрах хүрээ нь зарим улсад (Австри, Бельги, Франц, Грек, Итали, Люксембург, Португал) "үүргээ гүйцэтгэх явцад илэрхийлсэн үзэл бодол"-ыг өргөн хүрээнд тайлбарлаж, парламентын гадна хэлсэн мэдэгдэлд ч хамааруулдаг. Харин бусад улсад (Дани, Нидерланд, Ирланд, Финланд, Герман) зөвхөн танхим болон хорооны хуралдааны үеэр хэлсэн үгэнд хамаардаг. Хугацааны хувьд ихэнх улсад (Бельги, Дани, Франц, Герман, Грек, Ирланд, Итали, Люксембург, Нидерланд, Португал, Испани, Швед) хугацаагүй буюу мандат дууссан ч бүрэн эрхийн хугацаанд хэлсэн үг, илэрхийлсэн саналынхаа төлөө хариуцлага хүлээдэггүй буюу хамгаалалт үйлчилдэг. Харин Австри, Финланд зэрэгт зөвхөн мандатын хугацаанд хүчинтэйгээр үйлчилдэг.

Хоёрдугаарт, Европын Зөвлөлийн Парламентын Ассамблейн (PACE) дотоод журмын дүрмийг (Parliamentary Assembly of the Council of Europe, 2023) харвал, Европын Холбооны Дархан эрх, халдашгүй байдлын тухай протоколтой холбоотойгоор хэрэгжих зохицуулалтыг тусгасан байна. Тухайлбал дүрмийн 73 дугаар хэсэгт "Төлөөлөгчид болон орлогчдын бүрэн эрхийг түдгэлзүүлэх"-д холбогдох зохицуулалтыг оруулсан байна. Дүрмийн 73.1 дэх хэсэгт "Ассамблейн гишүүд нь 1949 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн "Европын Зөвлөлийн Дархан эрх, халдашгүй байдлын прокотол" болон 1952 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн нэмэлт протоколд заасан дархан эрх, халдашгүй байдлын эрхийг эдэлнэ. Энэхүү дархлааг Ассамблейн бүрэн бүтэн байдлыг хамгаалж, парламентын гишүүн албан тушаалаа хэрэгжүүлэхэд хараат бус байдлыг баталгаажуулах зорилгоор олгоно" хэмээн (Parliamentary Assembly of the Council of Europe, 2023) тусгасан.

<u>Гуравдугаарт,</u> Европын хүний эрхийн конвенцын (Council of Europe, 1953)10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй. Энэхүү эрх нь үзэл бодлоо баримтлах, мэдээлэл болон үзэл санааг ямар ч төрийн байгууллагаас саад учруулахгүйгээр, хил хязгаар үл харгалзан хүлээн авах, түгээх эрхийг багтаана. Энэ зүйл нь радио, телевиз, киноны байгууллагын үйл ажиллагаанд төрөөс тусгай зөвшөөрөл шаардахыг хориглохгүй" хэмээн заасан. Энэ заалтыг парламентын гишүүдийн хувьд шууд "хариуцлагаас ангид байх" агуулга, үг хэллэг байхгүй боловч зарчим нь парламентын дархан эрх (immunity)-ийн хүрээнд, ялангуяа 10 дугаар зүйл (Илэрхийлэх эрх чөлөө) болон түүнд холбогдох шүүхийн практик, тайлбаруудаар дамжин тайлбарлагдана гэж үздэг байна. Тухайлбал, энэ хүрээнд парламентын дархан эрхийн онолыг зөв ойлгохын тулд Европын Хүний Эрхийн Шүүхийн (ЕХЭШ) практикийг авч үзэх шаардлагатай хэмээн үздэг. Энэ талаар Нидерландын Утрехтийн Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн профессор Ремко Нехмелман (Remco Nehmelman) болон Утрехтийн Их сургуульд судлаач Макс Вецо (Max Vetzo) нарын "Үг хэлэх эрх чөлөө халдлагад өртөхүй" ("Freedom of Speech under Attack") хэмээх ном дахь "Парламентын дархан эрхийн өргөтгөл" ("Extension of Parliamentary Immunity") хэмээх өгүүлэлдээ дурдаж тайлбарласан (Remco Nehmelman., 2011) байна. Шүүхэд хэрэглэсэн хэрэглээг харвал,

Европын Хүний Эрхийн Шүүх парламентын дархан эрх (non-liability) буюу парламентын хэлэлцүүлгийн үеэр хэлсэн үг, өгсөн саналд хуулийн хариуцлага хүлээхгүй байх зарчмыг үнэмлэхүй хамгаалалт гэж (Remco Nehmelman., 2011) үздэг. Энэхүү хамгаалалт нь зарим үед Европын хүний эрхийн конвенцын 6 дугаар зүйлээр (Council of Europe, 1953) баталгаажсан “шударга шүүхээр шүүлгэх эрх”-ийг хязгаарлаж болох тул Шүүх (1) Хэрэв мэдэгдэл парламентын үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн бол дархан эрхийг үнэмлэхүйгээр хэрэгжүүлнэ; (2) Харин парламентын үйл ажиллагаатай шууд холбоогүй мэдэгдэл бол энэ хамгаалалт автоматаар үйлчлэхгүй, тухайн нөхцөл байдлаас хамаарч шалгагдана хэмээх тэнцвэрийг хийдэг байна.

2.2. Халдашгүй байдал (inviolability)-д холбогдох олон улсын эрх зүйн зохицуулалт

Парламент бол хууль тогтоох дээд байгууллага бөгөөд энэхүү үндсэн үүргээс гадна гүйцэтгэх засаглалыг хянаж, үйл ажиллагаанд нь хариуцлага тооцдог. Энэ хариуцлагыг хэрэгжүүлэхийн тулд үндэсний хууль тогтоомжийн системүүд парламентын гишүүдэд хууль зүйн хамгаалалт олгосон байх нь түгээмэл бөгөөд энэ нь Үндсэн хуультай нийцүүлэн тэднийг өөрсдийн оноогдсон үүргийг хэрэгжүүлэх боломжийг олгодог. Энэ хамгаалалтыг парламентын халдашгүй байдал хэмээн нийтлэгээр нэрлэдэг. Парламентын халдашгүй байдлын үндсэн зарчмыг харьцуулсан судалгааны эхний хэсэгт тайлбарласан хүрээнд (1) хариуцлагаас чөлөөлөгдөх (non-accountability) буюу парламентын гишүүд танхим дотор илэрхийлсэн үзэл бодол, өгсөн санал болон үүргээ хэрэгжүүлэх хүрээнд хийсэн үйлдлийнхээ төлөө иргэний, эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээхгүй байх зарчим; (2) халдашгүй байдал. (inviolability) буюу баривчлагдахаас, саатуулагдахаас ангид байх, зарим тогтолцоонд парламентын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байгаад ил баригдсан тохиолдлоос бусад үед зөвхөн парламентын зөвшөөрлөөр баривчилж, яллагдагчаар татаж болох зарчим тус тус хамаарна.

Парламентын халдашгүй байдал (хариуцлагаас чөлөөлөгдөх ба халдашгүй байдал)-д холбогдох олон улсын олон баримт бичгүүд хууль тогтоогчдыг үүргээ хэрэгжүүлэх явцад эрүүгийн болон иргэний хариуцлагаас чөлөөлөхийг зөвшөөрдөг бөгөөд дараах баримт бичгүүдэд нийтлэгээр зохицуулсан байна. Үүнд:

Хүснэгт 11. Парламентын халдашгүй байдалд холбогдох олон улсын эрх зүйн зохицуулалт

Ерөнхий ангилал	Хамаарах зохицуулалт агуулсан баримт бичиг	Хамаарах халдашгүй байдал	Тайлбар
НҮБ болон олон улсын түвшин	НҮБ-ын дархан эрх, тусгай эрхийн тухай конвенц (1946) (Convention on the Privileges and Immunities of the United Nations, 1946)	Халдашгүй байдал (inviolability) буюу эрүү, иргэний хариуцлагаас чөлөөлөгдөх	НҮБ-ын албан тушаалтнууд албан үүргийнхээ хүрээнд үйлдсэн хэрэгт эрүүгийн/иргэний хариуцлага хүлээхгүй.
	Венийн дипломат харилцааны тухай конвенц (1961) (Vienna Convention on Diplomatic Relations, 1961)		Дипломат төлөөлөгчид эрүүгийн болон ихэнх иргэний шүүхийн харьяаллаас бүрэн чөлөөлөгдөх бөгөөд тэднийг баривчлах, саатуулахыг хориглодог. Тэдний бие, нэр төр, эрх чөлөө, төлөөлөгчийн газрын байр нь халдашгүй дархан эрхтэй.
	Консулын харилцааны тухай конвенц (1963)		Консулын албан хаагчид зөвхөн албан үүргийн хүрээнд хийсэн үйл ажиллагаандаа холбогдуулан эрүүгийн болон иргэний

	(Vienna Convention on Consular Relations, 1963)		хариуцлагаас чөлөөлөгдөнө. Энэ нь дипломат дархан эрхээс илүү хязгаарлагдмал бөгөөд “functional immunity”-ийн зарчимд тулгуурлана.
	Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм (1998) (Rome Statute of the International Criminal Court, 1998)		Төрийн тэргүүн, өндөр албан тушаалтан, парламентын гишүүн ч байсан ялгаагүй, Олон улсын эрүүгийн шүүхийн харьяалалд багтах гэмт хэрэг (геноцид, дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, түрэмгийлэл) үйлдсэн бол дархан эрх эдлэхгүй. Албан тушаал нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болж үл чадна.
Европын холбоо ба Европын бүс нутгийн зохицуулалт	Дархан эрх, халдашгүй байдлын тухай протокол (Protocol on the Privileges and Immunities)	Халдашгүй байдал (inviolability) буюу эрүү, иргэний хариуцлагаас чөлөөлөгдөх	Европын Холбооны албан тушаалтнуудад үзүүлэх дархан эрх, татварын чөлөөлөлт, шүүхийн харьяалал, онцгой хамгаалалт зэрэг үндсэн баталгааг тогтоосон. Энэ нь байгууллагын бие даасан ажиллагааг хангах зорилготой протокол болно.
	Европын Холбооны Үйл ажиллагааны тухай гэрээ (Treaty on the Functioning of the European Union);		ЕХ-ны институцийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, парламентын гишүүдийн статустай холбогдох зарим дархан эрх, эрх зүйн баталгааг тодорхойлсон.
	Европын парламентын Дотоод журам (Rules of Procedure of the European Parliament);		Парламентын гишүүдийн ажиллах дэг, халдашгүй байдлын хэрэгжилт, эрх үүргийн хүрээг зохицуулсан. Энэ журам нь парламентын бие даасан байдлыг хангах механизмын нэг хэсэг болдог.
	Европын Хүний эрхийн конвенц (European Convention on Human Right);		Хүний эрхийн хамгаалалт, шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрх зэрэг зарчмуудыг баталгаажуулснаар парламентын гишүүний халдашгүй байдлыг хүний эрхийн хамгаалалтын хүрээнд тэнцвэржүүлэх зохицуулалттай.
	Европын парламентын гишүүдийн халдашгүй байдлын тухай журам, Протокол		Европын парламентын гишүүдийн халдашгүй байдлын хүрээ, хэрэглэх нөхцөл, үүнийг хязгаарлах үндэслэлийг нарийвчлан тогтоосон. Улс төрийн дарамтаас ангид байх баталгаа хэмээн үздэг.
	Ардчиллын төлөөх Европын комисс (Венецийн комисс)-ын Парламентын дархан эрхийн хамрах хүрээ болон түүнийг түдгэлзүүлэх тухай тайлан (Report on the Scope and Lifting of Parliamentary Immunities)		Европын Зөвлөлийн зөвлөх байгууллага болох Венецийн комисс нь парламентын дархан эрхийн хамрах хүрээ, түүний зөрчил, тэнцвэрийн асуудлыг дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд тайлбарласан
Ази, Номхон далайн бүсийн зарим улс орнуудын хамтын ажиллагааны баримт бичгүүд	АСЕАН-ын дархан эрх, халдашгүй байдлын тухай хэлэлцээр (2011) (ASEAN Agreement on the Privileges and Immunities, 2011)	Халдашгүй байдал (inviolability) буюу эрүү, иргэний хариуцлагаас чөлөөлөгдөх	АСЕАН-ы гишүүн орнууд болон тэдгээрийн төлөөлөгчдөд олон улсын байгууллагын түвшинд дархан эрх, халдашгүй байдлыг олгосон баримт бичиг байна. Энэ нь гишүүн орнуудын төлөөлөгчид, албан тушаалтнууд, Нарийн бичгийн дарга нарын газар зэрэгт эрүүгийн болон иргэний хариуцлагын хамгаалалт олгож, АСЕАН-ы үйл ажиллагааг бие даан, үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

	Ази Номхон далайн парламентын ассамблейн (APA) тогтоолууд (Asian Parliamentary Assembly (APA))		Бүс нутгийн парламентуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор баталсан тогтоолууд бөгөөд парламентын гишүүдийн эрх зүйн баталгаа, дархан эрхийн хэрэгжилтийг дэмжих, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулахад чиглэдэг. Эдгээр тогтоолууд нь гишүүн улсын парламентад хамтын ажиллагааны удирдамж, зарчмын зөвлөмж болдог.

Эх сурвалж: Судлаачийн ангилан боловсруулснаар.

Дээрхээс парламентын халдашгүй байдалтай холбоотой зохицуулалтаас ***НҮБ болон олон улсын түвшний*** эрх зүйн зохицуулалтыг дэлгэрүүлэн харвал:

1. НҮБ-ын дархан эрх, тусгай эрхийн тухай конвенц (1946);
2. Венийн дипломат харилцааны тухай конвенц (1961);
3. Консулын харилцааны тухай конвенц (1963);
4. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм (1998);

Нэгдүгээрт, Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдсан цагаасаа эхлэн өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх, зорилгоо биелүүлэхийн тулд гишүүн улсуудын нутаг дэвсгэр дээр эрх зүйн тодорхой чадамж, дархан эрх, тусгай эрх эдлэх шаардлагатай гэж үзсэн (Nations, 1946) байдаг. Энэ хүрээнд НҮБ-ын Дүрмийн 104, 105 дугаар зүйлд НҮБ болон түүний төлөөлөгчид, албан тушаалтнуудад үзүүлэх ёстой эрх зүйн хамгаалалтыг тусгасан бөгөөд хэрэгжилтийг баталгаажуулалт болж 1946 оны 2 дугаар сарын 13-нд Ерөнхий Ассамблейгаас “Нэгдсэн Үндэстний Байгууллагын дархан эрх, тусгай эрхийн тухай конвенц”-ийг баталж НҮБ-ын олон улсын эрх зүйн байр суурийг тодорхойлж, гишүүн улсуудад соёрхон нэгдэхийг санал болгосон (Nations, 1946) байдаг. Энэхүү конвенц нь НҮБ-ын эрх зүйн этгээдийн байдал, өмч хөрөнгө, санхүү, архивын халдашгүй байдал, татварын чөлөөлөлт зэрэг өргөн хүрээний зохицуулалтыг агуулдаг бөгөөд тэдгээрийн дотор байгууллагын албан тушаалтнуудын дархан эрх, тусгай эрхийг нарийвчлан тогтоосон 18 дугаар хэсэг зохицуулалт (Nations, 1946) байна. НҮБ-ын дархан эрх, тусгай эрхийн тухай конвенц (1946)-ын 18 дугаар зүйлд НҮБ-ын албан тушаалтнууд албан үүргийнхээ хүрээнд хийсэн үйлдэлдээ эрүүгийн/иргэний хариуцлага хүлээхгүй байх зохицуулалтыг тусгасан байдаг. Уг зүйлд “Нэгдсэн Үндэстний Байгууллагын албан тушаалтнууд дараах дархан эрх эдэлнэ” хэмээгээд зүйлийн (а)-д “Албан үүргээ гүйцэтгэх явцад хэлсэн, бичсэн үг болон хийсэн бүх үйлдлийн хувьд шүүхийн харьяаллаас ангид байх” хэмээн (Nations, 1946) тусгасан.

Хоёрдугаарт, Венийн дипломат харилцааны тухай конвенц (1961) буюу орчин үеийн олон улсын харилцаа, дипломат ажиллагааны суурь зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлсон олон улсын гэрээ (United Nations, 1961) байна. Конвенц 1961 онд батлагдаж, 1964 оноос хүчин төгөлдөр болсон. Ерөнхийдөө дипломат харилцааг зохицуулдаг дүрмийг кодификац[55], дипломат төлөөлөгчийн газрууд болон тэдгээрийн ажилтнуудын эрх, дархан эрх, тусгай эрхийг олон улсын түвшинд тогтоосон үндсэн гэрээ хэмээн үздэг. Конвенцын гол зорилго нь тусгаар тогтносон улсуудын хоорондын найрсаг харилцааг дэмжиж, дипломат төлөөлөгчийн газруудын үйл ажиллагаа болон дипломат ажилтнуудын эрх зүйн байдлыг нэг мөр, тодорхой стандартын дагуу зохицуулахад оршдог. Конвенцоор дипломат ажилтнуудын дархан эрх, халдашгүй байдал, татварын чөлөөлөлт, харилцаа холбооны эрх чөлөө, мөн төлөөлөгчийн газрын байр, өмч хөрөнгийн халдашгүй байдлыг баталгаажуулсан (United Nations, 1961). Тухайлбал, Конвенцын 29 дүгээр зүйлд ““Дипломат төлөөлөгчийн халдашгүй дархан эрхийг хүндэтгэнэ. Төлөөлөгч аливаа хэлбэрийн баривчилгаа, саатуулагдалтад өртөхгүй. Хүлээн

[55] Кодификац (codification) гэдэг нь хууль зүйн ойлголт, зохицуулалтыг цэгцтэй, эмхэтгэсэн, нэг мөр болгож, эрх зүйн тодорхой байдал бий болгох үйл явц юм (United Nations, 1947).

авагч улс түүнийг зохих хүндэтгэлтэйгээр хандаж, түүний бие, эрх чөлөө, нэр төрд халдах аливаа үйлдлийг таслан зогсооход шаардлагатай бүх арга хэмжээг авна" гэж (United Nations, 1961) заасан. Мөн 30 дугаар зүйл "Дипломат төлөөлөгчийн хувийн орон сууц нь төлөөлөгчийн газрын байртай адил халдашгүй дархан эрх болон хамгаалалтаар хангагдана. Түүний бичиг баримт, захидал харилцаа, мөн 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд өмч хөрөнгө нь халдашгүй дархан эрх эдэлнэ" хэмээн (United Nations, 1961) тусгасан. Энэхүү Венийн дипломат харилцааны тухай конвенц (1961) дахь халдашгүй байдлын талаарх зохицуулалт нь парламентын гишүүний халдашгүй байдалтай шууд холбоотой зохицуулалт биш боловч (1) Институцийн хараат бус байдлыг баталгаажуулах зорилго буюу дипломатын халдашгүй байдал нь олон улсын харилцаанд улс хоорондын найрсаг харилцаа, харилцан итгэлцлийг хамгаалдаг бол парламентын халдашгүй байдал нь дотоодын улс төрийн тогтолцоонд хууль тогтоох байгууллагын хараат бус байдал, эрх мэдлийн тэнцвэрийг хамгаалдаг (Bianchi, 2016); (2) Үйл ажиллагааны чөлөөт байдлыг хангах механизм буюу аль аль зохицуулалт нь хувь хүнийг хамгаалах замаар тухайн институцийн үйл ажиллагаа саадгүй явагдах нөхцөлийг бүрдүүлдэг (Erskine, 2004) үндсэн зарчимтай гэх хоёр үндсэн үзэл баримтлалаар холбогдоно.

<u>Гуравдугаарт,</u> Консулын харилцааны тухай конвенц (1963)-д консулын ажилтнууд албан үүргийнхээ хүрээнд үйлдсэн хэрэгт эрүүгийн/иргэний хариуцлагаас чөлөөлөгдөх зохицуулалтыг (United Nations, 1963) тусгасан. Тухайлбал, "Консулын албан хаагчид болон консулын ажилтнууд нь консулын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад хийсэн үйл ажиллагаатай холбогдуулан хүлээн авагч улсын шүүх, захиргааны байгууллагад хариуцлагад татагдахгүй" хэмээн заасан байдаг. Энэ нь консулын албан хаагчид өөрийн албан ёсны консулын үүрэг гүйцэтгэх хүрээнд хийсэн үйл ажиллагааны улмаас хүлээн авагч (байрлаж буй) улсын шүүхийн болон захиргааны байгууллагад хариуцлага хүлээхгүй гэсэн үг (United Nations, 1963) юм. Гэвч дипломат төлөөлөгчийн тухай Венийн конвенцоор олгогддог бүрэн дархан эрхээс ялгаатай нь консулын дархан эрх нь ерөнхийдөө зөвхөн албан үүргийн хүрээнд хийсэн үйлдэлд хамаардаг (United Nations, 1963) байна.

Дөрөвдүгээрт, Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм (1988) нь Ром хотод 1998 онд батлагдсан олон улсын гэрээ бөгөөд 2002 оны 7 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон (International Criminal Court , 1978). Дүрмээр Олон улсын эрүүгийн шүүх (ICC)-ийг байгуулж, түүний бүтэц, харьяалал, ажиллагааны үндсэн дүрмийг тогтоосон. Дүрэм нь хүнд төрлийн олон улсын гэмт хэрэг болох геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны болон түрэмгийлэл үйлдэх гэмт хэрэгт хамаарах харьяаллыг тогтоож хянан шийдвэрлэдэг (International Criminal Court , 1978). Мөн дүрмийн 27 дугаар зүйлд тодорхойлсончлон төрийн тэргүүн, парламентын гишүүн, сайд, эсхүл төрийн албан хаагч хэн байх нь үл харгалзан ямар нэгэн дархан эрх эдлэхгүй бөгөөд албан тушаал нь гэмт хэрэг үйлдсэн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болж чадахгүй болохыг (International Criminal Court , 1978) тодорхойлсон. Тухайлбал, 27 дугаар зүйлд "Албан тушаалын байдлаар шалтаг заахыг үл зөвшөөрөх" буюу дараах хоёр зохицуулалт (Erskine, 2004) [56]байна. Үүнд.

1. Энэхүү дүрмийг албан тушаалын байдлын үндсэн дээр ямар нэг ялгавар гаргахгүйгээр бүх этгээдэд нэгэн адил байдлаар хэрэглэнэ. Түүнчлэн, төрийн буюу засгийн газрын тэргүүн, засгийн газрын буюу парламентын гишүүн, засгийн газрын албан хаагч зэрэг албан тушаалын байдал нь ямар ч тохиолдолд энэхүү дүрмийн дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй бөгөөд энэ нь шийтгэх тогтоолыг хөнгөрүүлэх үндэслэл болохгүй.

[56] Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (1978) "Монгол Улсын олон улсын гэрээ: Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм". Хандах: https://legalinfo.mn/mn/detail?lawId=1217

2. Үндэсний буюу олон улсын эрх зүйн дагуу байлаа ч гэсэн аливаа этгээдийн албан тушаалын байдалтай холбоотой байж болох дархан эрх буюу байцаан шийтгэх ажиллагааны тусгай хэм хэмжээ нь тухайн этгээдийн хувьд Шүүх шүүн таслах ажиллагаагаа хэрэгжүүлэхэд саад учруулах ёсгүй.

Үүнээс Парламентын гишүүний халдашгүй байдлын зохицуулалт болон Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 27 дугаар зүйлд туссан дархан эрхийн үл хамаарах зарчим нь хоёулаа эрх мэдлийн хэрэгжилт, институцийн үйл ажиллагааны чөлөөт байдлыг хамгаалахад чиглэдэг ч эсрэг чиглэлтэй утга санааг илэрхийлдэг (Liu, 2024) байна. Парламентын халдашгүй байдал нь гишүүдийг улс төрийн дарамтад автахгүйгээр хууль тогтоох үүргээ гүйцэтгэхэд нь баталгаа болж, дотоодын ардчилсан тогтолцооны тогтвортой байдлыг дэмждэг бол Ромын дүрэм нь олон улсын эрүүгийн шүүхийн харьяалалд хамаарах ноцтой гэмт хэргүүдийн хувьд ямар ч төрийн албан тушаал, парламентын бүрэн эрхийг хамгаалах боломжгүй болгосноор эрх мэдэл бүхий этгээдүүдийг хариуцлагаас ангид үлдээхгүй байх зарчмыг (Liu, 2024) тогтоожээ. Өөрөөр хэлбэл, парламентын халдашгүй байдал нь улс төрийн институцийн хараат бус байдлыг хамгаалдаг бол олон улсын хэмжээнд хүчийн төгөлдөр үйлчилж буй Ромын дүрмийн зохицуулалт нь институцийн түвшинд бус, дэлхий нийтийн хэмжээнд хүний эрх, шударга ёсыг хамгаалах зорилготой хязгаарлалт бүхий хамгаалалт байна.

Парламентын халдашгүй байдалтай холбоотой зохицуулалтаас ***<u>Европын холбоо ба Европын бүс нутгийн эрх зүйн зохицуулалтыг</u>*** харвал дараах зохицуулалт бүхий баримт бичгүүдийг хамаарч байна. Үүнд:

1. Европын Холбооны Дархан эрх, халдашгүй байдлын тухай протокол (Protocol on the Privileges and Immunities);
2. Европын Холбооны Үйл ажиллагааны тухай гэрээ (Treaty on the Functioning of the European Union);
3. Европын парламентын Дотоод журам (Rules of Procedure of the European Parliament);
4. Европын Хүний эрхийн конвенц (European Convention on Human Right);
5. Ардчиллын төлөөх Европын комисс (Венецийн комисс)-д Европын Зөвлөлийн зөвлөх байгууллага болох Венецийн комисс парламентын дархан эрхийн хамрах хүрээ, түдгэлзүүлэлтийн талаарх тайлан тус тус байна. Тус бүрийн дэлгэрүүлэн тайлбарлавал:

Нэгдүгээрт, Европын Холбооны Дархан эрх, халдашгүй байдлын тухай протокол (PPI) нь ЕХ-ны анхдагч эрх зүйн эх сурвалжийн статустай бөгөөд ЕХ нь гишүүн орнуудын нутаг дэвсгэр дээр өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай эрх, дархан эрхийг эдлэх нөхцөлийг тогтоож өгдөг. Энэ протокол нь Европын Холбооны гишүүдийн халдашгүй байдлын зохицуулалтыг дараах байдлаар тогтоосон байдаг. Үүнд:

- Протоколын 10 дугаар зүйлд “Европын Парламентын чуулганы үеэр гишүүд нь дараах эрх эдэлнэ: a) Өөрийн улсын нутаг дэвсгэр дээр тухайн улсын парламентын гишүүдэд олгогддог дархлаатай адил эрх; b) Бусад гишүүн улсын нутаг дэвсгэр дээр баривчилгаа болон хууль зүйн хариуцлагаас бүрэн дархлагдах эрх байна. Эдгээр дархлааны эрх нь Европын Парламентын хуралд ирж, буцах замд ч мөн адил хүчинтэй байна.Гэмт хэрэг үйлдэж байхдаа газар дээр нь илэрсэн тохиолдолд дархлааг шаардах боломжгүй бөгөөд Европын Парламент гишүүний дархлааг түдгэлзүүлэх эрхээсээ татгалзах боломжийг энэ нь хязгаарлахгүй” хэмээн заасан (European Union, 2003). Энэ заалтаар яллагдагчаар татагдахаас, баривчлагдахаас хамгаалах хувийн дархан эрх (халдашгүй байдал)-г зохицуулсан. Заалтын хамрах хүрээ нь Европын парламентын гишүүдийн хараат бус байдлыг баталгаажуулах

зорилгоор тэднийг баривчлах, яллагдагчаар татах зэргээс хамгаалах зорилготой. ЕХ-ны гишүүн улс өөрийн улсын үндэсний парламентын гишүүдэд олгогддог дархан эрхийг эдлэх бөгөөд улс орон бүрийн зохицуулалтаас хамаарч ялгаатай байна. Европын парламентын гишүүд баривчлах, яллагдагчаар татах аливаа ажиллагаанаас ангид байна. Түүнчлэн Европын парламентын хуралдаанд ирэх, буцах замд ч энэхүү дархан эрх үйлчилнэ. Үүнийг "Нийгэмлэгийн дархан эрх" гэж үздэг. Онцгой тохиолдлууд**:** Гишүүн гэмт хэрэг үйлдэж байхад нь ил баригдсан тохиолдолд (flagrante delicto) дархан эрхийг шаардах, ашиглах боломжгүй. Мөн хохирол барагдуулах, шийтгэлийн шинжтэй бол иргэний хэрэг байсан ч дархан эрх үйлчлэхгүй байж болно. Гишүүн гэрч, эсхүл шинжээчээр дуудагдсан тохиолдолд ч хамаарахгүй, харин мандаттай холбоотой нууц мэдээлэл, эсхүл парламентын үүрэгт саад учруулах бол энэ зохицуулалт хамаарна.

Энэ дархан эрх Европын парламентын "хуралдааны үед" хүчин төгөлдөр байна. Бодит байдал дээр энэ нь таван жилийн бүрэн эрхийн хугацааны турш хүчинтэй бөгөөд гишүүний бүрэн эрх дуусахад дуусгавар болно. Энэ нь бүрэн эрхийн хугацаанаас өмнө болон хугацаанд үйлдсэн үйлдлийг хамарна. Европын парламент энэхүү дархан эрхийг түдгэлзүүлэх эрхтэй**.** Түдгэлзүүлэх санал гаргадаг боловч улс төрийн зорилготой мөрдөн шалгах сэжиг (fumus persecutionis) байгаа бол түдгэлзүүлэхээс татгалздаг.

Хоёрдугаарт, Европын Холбооны Үйл ажиллагааны тухай гэрээ (TFEU)-ний 343 дугаар зүйлд Европын Холбоо өөрийн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай эрх, дархан эрх эдлэх бөгөөд эдгээр нь Европын Холбооны Дархан эрх, халдашгүй байдлын тухай протокол (PPI)-д заасан нөхцөлөөр хэрэгжинэ гэж заасан.

Гуравдугаарт, Европын парламентын Дотоод журам (RoP)-д Дархан эрх, халдашгүй байдлын тухай протокол (PPI)-д заасан дархан эрхийн хамрах хүрээ, хэрэгжилтийг тодруулсан. Үүнд, парламентын дархан эрх нь хувь хүний давуу эрх бус, харин парламент болон түүний гишүүдийн хараат бус байдлын баталгаа болохыг онцолдог. Мөн дархан эрхийг түдгэлзүүлэх, эсхүл хамгаалах журам тодорхой тусгагдсан байдаг. Энэ асуудлыг Хууль зүйн асуудал эрхэлсэн хороо хариуцан шийдвэрлэдэг бөгөөд ерөнхий зарчмын дагуу, хэрэв улс төрийн зорилгоор явуулсан ажиллагаа гэх үндэслэл, нотолгоо байхгүй бол, тус хороо гишүүний халдашгүй байдлыг түдгэлзүүлэх санал гаргадаг.

Дөрөвдүгээрт, Европын Хүний эрхийн конвенц (ECHR)-ийн 6 дугаар зүйл (шударга шүүхээр шүүлгэх эрх) болон 10 дугаар зүйл (үзэл бодлоо илэрхийлэх эрх) нь парламентын дархан эрх ба хүний үндсэн эрхийн тэнцвэрийг хангахтай холбоотой зохицуулалтыг агуулдаг. Европын Хүний эрхийн шүүх (ECtHR) практикт сонгогдсон төлөөлөгчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн ач холбогдол болон парламентын халдашгүй байдлын хязгаарлалт, ялангуяа парламентын гадна илэрхийлсэн мэдэгдэл болон бодит баримтад хамаарах асуудлыг тайлбарласан байдаг.

Тавдугаарт, Ардчиллын төлөөх Европын комисс (Венецийн комисс)-оос парламентын дархан эрхийн хамрах хүрээ, түдгэлзүүлэлтийн талаар "Парламентын дархан эрхийн хамрах хүрээ болон түүнийг түдгэлзүүлэх тухай тайлан (Report on the Scope and Lifting of Parliamentary Immunities)" тайланг (Venice Commission, 1998) баталсан. Тус комисс үндэсний хуулиудын абсолют болон хувийн дархан эрхийн зохицуулалтыг судалж, хууль дээдлэх зарчмыг хамгаалах хэрэгцээтэй харьцуулсан. Комисс Европын парламентын дархан эрхийн зохицуулалт нь үндэсний шинэчлэлд жишээ болох боломжтой, нийтлэг европын ойлголтыг тусгаж буйг онцолсон (Venice Commission, 1998).

ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Парламентын гишүүдийн халдашгүй байдлын хоёр үндсэн хэлбэр болох хариуцлагаас чөлөөлөх (non-accountability) болон халдашгүй байдал (inviolability) нь парламентын бие даасан, чөлөөтэй үйл ажиллагааг хангах үндсэн баталгаа болж олон улсын түвшинд нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн зохицуулалт юм. Сонгон судалсан БНСУ, БНЭстУ, ХБНГУ, Япон Улсын хууль тогтоомжийн зохицуулалтаас харахад дээрх хоёр зохицуулалт нь Үндсэн хууль болон органик хуулиар тусгайлан баталгаажсан бөгөөд эрх мэдлийн тэнцвэр, парламентын бие даасан байдлыг хамгаалах ач холбогдолтой байна.

Хариуцлагаас чөлөөлөгдөх (non-accountability) зохицуулалтын хувьд, парламентын гишүүдийн хэлсэн үг, өгсөн саналд хариуцлагаас чөлөөлөх зохицуулалтын нийтлэг зорилго нь парламентын бие даасан ажиллагааг баталгаажуулах, гишүүдийн чөлөөтэй мэтгэлцэх орчныг бүрдүүлэхэд чиглэж байна. Гэвч хууль тогтоомжийн үйлчлэх хүрээ, хязгаар өөр өөр буюу БНСУ, Япон зэрэг улсад уг зохицуулалт парламентын дотоод сахилгын хяналттай хосолж ажилладаг бол, БНЭстУ-д гишүүдийн хараат бус байдалтай уялдан ажилладаг.

ХБНГУ-ын хувьд хариуцлагаас чөлөөлөх (indemnität) ба халдашгүй байдал (immunität)-ыг ялгаатай зохицуулалтаар нарийвчлан тогтоосон байна. Тухайлбал, хариуцлагаас чөлөөлөх (indemnität) нь парламентын гишүүдийн Бундестаг болон түүний хороодод хэлсэн үг, өгсөн саналын төлөө ямар нэгэн эрүүгийн, иргэний, эсхүл захиргааны хариуцлага хүлээлгэхээс бүрэн хамгаалах, цуцлагдашгүй шинжтэй тогтвортой хамгаалалт болдог. Харин тус улсад халдашгүй байдал (immunität) нь гишүүдийг тодорхой хугацаанд баривчлах, яллагдагчаар татах зэрэг эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанаас хамгаалах түр хугацааны хамгаалалт бөгөөд Бундестагийн зөвшөөрлөөр түдгэлзүүлэх боломжийг бий болгодог. Энэ хоёр түвшний зохицуулалт нь, нэг талаас парламент дахь чөлөөт мэтгэлцээнийг баталгаажуулах, нөгөө талаас гишүүдийн үйл ажиллагаа нь бусдын эрх, нэр төрийг санаатайгаар хохироохгүй байх тэнцвэрийг хангадаг байна.

Халдашгүй байдлын (inviolability) зохицуулалтын харьцуулалтыг харахад, тухайлбал, БНСУ-ын парламентын гишүүдийн халдашгүй байдлыг Үндсэн хуулийн 44, 45 дугаар зүйл болон Үндэсний Ассамблейн тухай хуулийн 26–28 дугаар зүйлд хуульчилсан бөгөөд энэ нь гишүүнийг чуулганы хугацаанд зөвшөөрөлгүйгээр баривчлах, саатуулахыг хориглох (inviolability), мөн танхим дотор хэлсэн үг, өгсөн саналынх нь төлөө хариуцлага хүлээлгэхгүй байх (non-accountability) гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Баривчлах зөвшөөрөл хүсэхэд Үндэсний Ассамблей 24-72 цагийн дотор санал хураах журам тогтоосон нь шүүхийн яаралтай ажиллагаа болон хууль тогтоох байгууллагын хэлэлцүүлгийн хоорондын тэнцвэрийг хангах зориулалттай. Гэвч практикт БНСУ-ын парламентын гишүүдийн халдашгүй байдалд холбогдох зохицуулалт нь улс төрийн нөхцөл байдлаас хамаарч өөр өөрөөр хэрэгжиж ирсэн хэмээгддэг. Үндэсний Ассамблейн гаргасан статистик мэдээллээс харахад, баривчлах зөвшөөрөл болон суллах тогтоолын хүсэлтийн ихэнх нь батлагдаагүй буюу хугацаа дууссанаар хэрэгсэхгүй болсон нь парламент гишүүдээ улс төрийн болон хууль эрх зүйн дарамтаас хамгаалах институцийн соёл давамгайлж буй боловч нөгөө талдаа улс төрийн хамгаалалтын хэрэгсэл болон ашиглагдах хандлагатай ажиглагдаж байна.

БНЭстУ-ын хувьд, Парламентын (Рийгикогугийн) гишүүдийн халдашгүй байдалтай холбоотой зохицуулалт нь хоёр үе шаттайгаар хэрэгждэг байна. Үүнд, нэгдүгээрт, “хэсэгчлэн түдгэлзүүлэх” үе шатанд эрүүгийн хэрэг үүсгэхийн өмнө нотлох баримт цуглуулах зорилгоор тодорхой процессын ажиллагаа (баривчлах, нэгжлэг, биеийн үзлэг, эд хөрөнгө хураах, тагнах гэх мэт) хийхийг зөвшөөрдөг бөгөөд энэ шат зарим нөхцөлд алгасагдаж болдог. Хоёрдугаарт, “бүрэн түдгэлзүүлэх” үе шатанд цуглуулсан нотлох баримтад үндэслэн Хууль зүйн хянан

шалгагч нь Рийгикогугийн чуулганаас яллах дүгнэлт бэлтгэх зөвшөөрөл авч, улмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилдэг. Үүнээс гадна хэсэгчлэн түдгэлзүүлэх шатанд процессын ажиллагаа явуулахын тулд гурван институцийн зайлшгүй зөвшөөрөл шаардлагатай байдаг нь онцлог зохицуулалт байна.

ХБНГУ-ын хувьд, Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт халдашгүй байдлыг зохицуулсан бөгөөд парламентын гишүүдийг өөрийн үүргээ хэрэгжүүлэхдээ эрүүгийн, эсхүл өөр төрлийн хариуцлага, дарамт шахалтаас айхгүйгээр ажиллах нөхцөлийг баталгаажуулах зорилготой. Энэ нь чөлөөт, нээлттэй улс төрийн мэтгэлцээнийг дэмжиж, ардчилсан тогтолцоонд зайлшгүй шаардлагатай маргаан хэлэлцүүлэг явуулах боломжийг хангадаг. Хэрэв халдашгүй байдлын зохицуулалт байхгүй бол гишүүд өөрийгөө цензурдэж, хууль эрх зүйн үр дагавраас айж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чадахгүй болох эрсдэлтэй. Энэ нь ардчилсан хэлэлцүүлэг явуулах боломжийг ноцтойгоор хязгаарлаж, парламент улс төрийн хүсэл зориг бүрэлдүүлэх үндсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болох нөхцөлийг бүрдүүлнэ гэж үздэг. Иймээс ХБНГУ-ын зохицуулалтын хүрээнд халдашгүй байдлын зохицуулалт болон гүтгэн доромжлох хэргийг нарийн хүрээнд тогтоосон нь ардчилсан нийгэмд чөлөөт улс төрийн хэлэлцүүлгийг баталгаажуулахын зэрэгцээ хувь хүний нэр төр, хувийн эрхийг хамгаалах тэнцвэрийг бий болгосон байна.

Харин Япон Улсад парламентын гишүүний халдашгүй байдлыг Үндсэн хуулийн 50, 51 дүгээр зүйл болон Үндэсний парламентын тухай хууль (Diet Law)-д хуульчилж, хариуцлагаас чөлөөлөх болон баривчлагдахаас ангид байх хоёр үндсэн зарчмыг зохицуулсан. Халдашгүй байдал нь чуулганы хугацаатай шууд уялдсан, тодорхой хугацааны хязгаарлалттайгаар онцлог бөгөөд гишүүний нэр хүндийг байнга хамгаалахад бус, парламентын хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангахад чиглэсэн хамгаалалт байна. Мөн Япон Улсын тогтолцооны онцлог нь халдашгүй байдлыг парламентын тухай хууль, танхим тус бүрийн дотоод журам, хамтарсан журам зэргээр олон түвшинд баталгаажуулснаар парламентын бие даасан ажиллагааг хамгаалдаг байна.

Харьцуулсан судалгаанд судлагдсан улс орнуудын Парламентын халдашгүй байдлын зохицуулалтыг харьцуулан харвал:

Хүснэгт 12. Судалгаанд хамрагдсан улсуудын парламентын халдашгүй байдлын харьцуулалт

Улс	Үндсэн хуулийн зохицуулалт	Хариуцлагаас чөлөөлөх хүрээ (Non-Liability)	Халдашгүй байх хүрээ (Inviolability)	Халдашгүй байдлыг түдгэлзүүлэх журам	Гол онцгой нөхцөл	Хариуцсан байгууллага
БНСУ	Үндсэн хуулийн 44, 45 дугаар зүйл	Танхим дотор хийсэн мэдэгдэл, өгсөн санал	Баривчлах, саатуулах ажиллагаанаас хамгаална	Үндэсний Ассамблейн зөвшөөрөл шаардагдана	*Flagrante delicto* (газар дээрээ баригдсан тохиолдол)	Үндэсний Ассамблей
БЭстУ	Үндсэн хуулийн 62 дугаар зүйл	Рийгикогугийн гишүүний хувиар илэрхийлсэн санал, өгсөн санал	Мөрдөн шалгах, саатуулах, эрүүгийн хэрэг үүсгэхээс хамгаалах	Эрх бүхий байгууллагаас гаргасан хүсэлтийг байнгын хороо авч хэлэлцээд, дараа нь парламентын нийт гишүүдийн энгийн олонхийн саналаар шийдвэрлэнэ	*Flagrante delicto* (газар дээрээ баригдсан тохиолдол)	Рийгикогу (парламентын хороо хянана)
ХБНГУ	Үндсэн хуулийн 46 дугаар зүйл	Бундестаг, эсхүл түүний байнгын хороодод хийсэн санал, мэдэгдэл	Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлтэй үйлдэлд баривчлах, эсхүл эрх чөлөөг хязгаарлах	Бундестагийн зөвшөөрөл шаардлагатай; мөн Бундестаг явагдаж буй ажиллагааг түдгэлзүүлэхийг шаардах эрхтэй	Гүтгэлгийн шинжтэй доромжлол (non-liability-д хамаарна); гэмт хэрэг үйлдэж байхдаа, эсхүл дараагийн өдөр нь баривчлагдсан тохиолдол	Бундестаг (Халдашгүй байдлын байнгын хороо хянана)

					(inviolability-д хамаарна)	
Япон	Үндсэн хуулийн 50, 51 дүгээр зүйл	Танхимын дотор хэлсэн үг, хэлэлцүүлэг, өгсөн санал	Чуулганы үед баривчлагдахаас чөлөөлөгдөнө	Баривчилгаа зөвхөн тухайн танхимын зөвшөөрлөөр хийгдэнэ; чуулганаас өмнө баривчлагдсан гишүүнийг танхимын шаардлагаар суллана	Цаг хугацааны хязгаарлалт: зөвхөн чуулганы үед хүчинтэй; чуулганаас өмнө баривчлагдсан гишүүнийг суллаж болно	Парламент (Төлөөлөгчдийн танхим, эсхүл Зөвлөхүүдийн танхим)

Эх сурвалж: Судлаачийн ангилан боловсруулснаар.

Сонгон судалсан Япон, БНСУ, БНЭстУ, ХБНГУ-ын хууль тогтоомж дахь зохицуулалтаас үзэхэд, парламентын халдашгүй байдлын эрх нь улс орон бүрийн хууль эрх зүйн тогтолцоо, ардчиллын хөгжлийн түвшинд харилцан адилгүй байдлаар хэрэгждэг ч хууль тогтоох байгууллагын бие даасан байдлыг хамгаалах, улс төрийн дарамтаас сэргийлэхийн зэрэгцээ гишүүдийн хууль зүйн хариуцлагаас зайлсхийхгүй байх тэнцвэрийг хадгалах зорилготой зохицуулалт нийтлэг байна.

НОМ ЗҮЙ

European Parliament. (2014). *Handbook on the imcompatibilities and immunity of the members of the European Parliament.* European Parliament: https://www.europarl.europa.eu/cmsdata/90771/Handbook%20on%20Immunity.pdf-ээс Гаргасан

United Nations. (1961). *Vienna Convention on Diplomatic Relations.* United Nations Treaty Series. Гаргасан 2025 оны September, https://legal.un.org/ilc/texts/instruments/english/conventions/9_1_1961.pdf-аас

Nations, U. (1946). *Convention on the Privileges and Immunities of the United Nations.* United Nations.

United Nations. (1947). *Statute of the International Law Commission.* United Nations.

United Nations. (1963). *Vienna Convention on Consular Relations.* United Nations.

International Criminal Court . (1978). *Rome Statute of the International Criminal Court.* International Criminal Court .

Liu, Y. (2024). Revisiting the Customary International Law Avenue: Immunity of State Officials of Non-Party States in the Enforcement Proceedings of the International Criminal Court. *Chinese Journal of International Law* , 123-149.

Venice Commission. (1998). *Report on the Scope and Lifting of Parliamentary Immunities.* Venice Commission.

Remco Nehmelman., M. V. (2011). Extension of Parliamentary Immunity. A. &. Ellian-Д, *Freedom of speech under attack.* The Hague: Eleven International Publishing.

Council of Europe. (1953). *European Convention on Human Rights.* Council of Europe.

European Central Bank (ECB). (2003). *Protocol on the Privileges and Immunities of the European Communities.* Frankfurt am Main: European Central Bank.

Parliamentary Assembly of the Council of Europe. (2023). *Rules of Procedure of the Parliamentary Assembly of the Council of Europe (PACE).* Strasbourg: Council of Europe.

Meyer-Goßner, W., & Schmitt, B. (2023). *Strafprozessordnung: StPO mit GVG, EGGVG und Nebengesetze.* München: C.H. Beck.

Ipsen, J. (2010). Parlamentarische Immunität in Deutschland. *Zeitschrift für Parlamentsfragen (ZParl), Vol. 41, No.2*, 123–140.

Bianchi, A. (2016). Immunity versus Human Rights: The Pinochet Case. *European Journal of International Law, 10*(2), 237–277.

Erskine, H. G. (2004). *Parliamentary Immunity: A Comprehensive Study.* Inter-Parliamentary Union.

South Korea: National Assembly. (2025). *Legislative Data Book (From the Constituent National Assembly to the 21st National Assembly).* National Assembly of South Korea.

European Union. (2003). *Protocol on the Privileges and Immunities of the European Communities.* Brussels: European Central Bank.

Venice Commission. (2014). *Report on the scope and lifting of parliamentary immunities adopted by the Venice Commission at its 98th plenary session.* Venice Commission.

OSCE. (2004). *Best practices in combating corruption - Chapter: Chapter 5: Political and judicial immunity.* OSCE.

Namuwiki. (2025). *불체포 특권 [Privilege from arrest]*. Namu Wiki: https://namu.wiki/w/%EB%B6%88%EC%B2%B4%ED%8F%AC%20%ED%8A%B9%EA%B6%8C#s-3.1-ээс Гаргасан